



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЛБӨР

Батсайхан ТЭМҮҮЛЭН

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРМИЙН ЗӨРЧИЛД
ХҮЛЭЭЛГЭХ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ҮР
НӨЛӨӨГ СУДЛАХ НЬ**



Мэргэжлийн индекс
042103

Бизнесийн эрх зүй
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдсан
Ю.Хорлоо /Ph.D/

Улаанбаатар 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЛБӨР



Батсайхан ТЭМҮҮЛЭН

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРМИЙН ЗӨРЧИЛД
ХҮЛЭЭЛГЭХ ХУУЛЬ ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ҮР
НӨЛӨӨГ СУДЛАХ НЬ**

**Мэргэжлийн индекс
042103**

**Бизнесийн эрх зүй
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил**

Удирдагч..... Ю.Хорлоо /Ph.D/

Улаанбаатар 2026

ГАРЧГИЙН ТОВЬЁОГ

МЭДЭГДЭХ ХУУДАС.....	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ	iii
ХҮСНЭГТэн мэдээллийн ЖАГСААЛТ	v
ЗУРГан мэдээллийн ЖАГСААЛТ	vi
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	viii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	ix
УДИРТГАЛ 1	
Судалгааны үндэслэл.....	1
Судлагдсан байдал	2
Судалгааны зорилго.....	4
Судалгааны зорилт.....	4
Судалгааны таамаглал	4
Судалгааны объект.....	4
Судалгааны хамрах хүрээ.....	4
Судалгааны шинэлэг байдал	4
БҮЛЭГ 1. ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ, ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРМИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ ба МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	6
1.1 Захиргааны эрх зүйн тухай.....	6
БҮЛЭГ 2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН нөхцөл БАЙДлын судалгаа	12
2.1 Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал.....	12
2.1.2 Аi камер буюу ухаалаг камерын хяналт	15
2.1.2.1 Аi камерт суурилсан замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх тогтолцоо.....	16
2.1.2.2 IREX буюу Монгол улсад ашиглаж буй ухаалаг камерын систем.....	18
2.1.3 Замын хөдөлгөөний зөрчлийн статистик мэдээлэл	18
2.1.3.1 Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн мэдээлэл	18
БҮЛЭГ 3. Судалгааны арга зүй	34
3.1 Судалгааны арга зүй	34
БҮЛЭГ 4. СУДАлгааны үр дүн	35

4.1 Судалгааны үндэслэл.....	35
4.2 Судалгааны зорилго.....	35
4.3 Судалгааны арга зүй	35
4.4 Судалгааны хязгаарлалт	35
4.5 Асуулгын болон ярилцлагын судалгааны үр дүн.	35
4.5.1 Асуулгын судалгаа.....	36
4.5.2 Асуулгын судалгааны дүгнэлт:.....	42
4.6 Ярилцлагын судалгаа.....	42
ДҮГНЭЛТ.....	54
САНАЛ ЗӨВЛӨМЖ	56
НОМ ЗҮЙ	58
ХАВСРАЛТ	60

МЭДЭГДЭХ ХУУДАС

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, эдийн засгийн их сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүндээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (CC BY-NC-ND) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Магистрантын нэр : Б.Тэмүүлэн

Гарын үсэг :

Огноо :

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд гүн туслалцаа үзүүлж үнэт цаг, зөвлөмжөө харамгүй хайрласан удирдагч багш Ю.Хорлоо /Ph.D/, СЭЗИС-ийн Бизнесийн эрх зүйн тэнхимийн багш нар болон ярилцлагын асуулганд оролцсон замын цагдаагийн алба хаагч нар, сурах үйлсийг маань дэмжсэн хайрт гэр бүл, ангийн болон ажлын хамт олон, найз нөхөд, судалгааны ажилд туслалцаа үзүүлсэн бүх хүмүүстээ гүн талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улсад сүүлийн жилүүдэд замын хөдөлгөөний дүрмийн зөрчил, зам тээврийн ослын тоо буурахгүй, харин нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 2020–2025 оны хооронд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдол 1.5 саяас 3.8 сая гаруй болж 253.3% өссөн нь энэ чиглэлийн хууль зүйн хариуцлагын үр нөлөөг дахин үнэлэх шаардлагатайг харуулж байна. Мөн бүртгэлтэй жолоочийн тооны тогтмол өсөлт нь замын хөдөлгөөний зөрчилд нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг болж байна.

Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд ногдуулах хууль зүйн хариуцлага нь торгууль ногдуулах, жолоодох эрх хасах, баривчлах гэсэн үндсэн гурван хэлбэрээр хэрэгжиж байгаа боловч эдгээр арга хэмжээний үр нөлөө бодит байдал дээр хангалттай түвшинд хүрэхгүй байна. Ялангуяа торгуулийн хөнгөлөлтийн тогтолцоо (тухайлбал 14 хоногийн дотор төлбөл 50 хувиар бууруулах) нь зарим тохиолдолд жолоочийг зөрчил гаргахад өөгшүүлэх сөрөг нөлөө үзүүлж байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд оногдуулж буй хууль зүйн хариуцлагын үр нөлөөг судалж, зөрчил бууруулахад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход оршино. Судалгаанд захиргааны эрх зүй, нийтийн эрх зүйн онолын хүрээнд Монгол Улсын Зөрчлийн тухай хууль болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зохицуулалтыг системчлэн судалсан. Үүний зэрэгцээ АНУ болон БНСУ-ын замын хөдөлгөөний зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог судалж, Монгол Улсын нөхцөл байдалтай харьцуулан дүн шинжилгээ хийсэн.

Мөн судалгааны ажлын хүрээнд чанарын судалгааны аргыг ашиглан жолооч нараас асуулгын судалгаа авч замын хөдөлгөөний дүрэм зөрчихөд нөлөөлөх шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон бөгөөд замын цагдаагийн албан хаагчдаас ярилцлагын судалгаа авч хууль зүйн хариуцлагын хэрэгжилт, үр нөлөөг үнэлсэн. Ингэснээр онол, хууль зүйн зохицуулалт, практик хэрэгжилтийг уялдуулсан цогц дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгааны үр дүнгээс харахад хууль зүйн хариуцлага нь тодорхой хэмжээнд сэргийлэх нөлөө үзүүлдэг боловч түүний үр нөлөө нь шийтгэлийн хатуу чанар, зайлшгүй хэрэгжилт (certainty), хяналтын тогтолцооны үр ашиг зэргээс ихээхэн хамаарч байна. Ялангуяа зөвхөн торгуулийн арга хэмжээ дангаараа хангалтгүй бөгөөд шаталсан шийтгэлийн тогтолцоо, тогтвортой хэрэгжилт бүхий хяналтын механизм илүү үр дүнтэй болох нь харьцуулсан судалгаанаас харагдаж байна.

Иймээс замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахын тулд хууль зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг бэхжүүлэх, шийтгэлийн үр нөлөөг нэмэгдүүлэх, жолоочийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

Түлхүүр үг: *Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил, Зөрчлийн тухай хууль, Захиргааны тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн статистик мэдээлэл.*

ABSTRACT

In recent years, the number of traffic rule violations and road accidents in Mongolia has not decreased; instead, it shows an increasing trend. For instance, between 2020 and 2025, the number of traffic violations increased from approximately 1.5 million to over 3.6 million, indicating the need to reassess the effectiveness of legal liability in this area. At the same time, the steady growth in the number of registered drivers has become one of the contributing factors to the rising level of violations.

In Mongolia, legal liability for traffic rule violations is primarily implemented through three main forms: fines, suspension of driving licenses, and detention. However, in practice, the effectiveness of these measures remains insufficient. In particular, the fine reduction system (for example, a 50% reduction if paid within 14 days) may, in some cases, encourage drivers to commit violations, as indicated by the research findings.

The main objective of this study is to examine the effectiveness of legal liability imposed for traffic rule violations in Mongolia and to determine its impact on reducing such violations. The study is based on the theoretical framework of administrative law and public law, and it systematically analyzes the legal regulations set out in the Law on Violations and the Law on Road Traffic Safety of Mongolia. Furthermore, a comparative analysis was conducted by examining the legal liability systems for traffic violations in the United States and the Republic of Korea, and comparing them with the Mongolian context.

In addition, qualitative research methods were employed. A questionnaire survey was conducted among drivers to identify the causes and conditions influencing traffic rule violations, while interviews were carried out with traffic police officers to assess the implementation and effectiveness of legal liability in practice. This approach enabled a comprehensive analysis integrating legal theory, regulatory frameworks, and practical enforcement.

The findings of the study indicate that legal liability has a certain deterrent effect; however, its effectiveness largely depends on the severity of penalties, the certainty of enforcement, and the efficiency of the monitoring system. In particular, fines alone are not sufficient, and a system of graduated sanctions, along with consistent enforcement mechanisms, proves to be more effective, as shown in the comparative analysis.

Therefore, it is concluded that in order to reduce traffic rule violations, it is necessary to improve the legal framework, strengthen enforcement, enhance the effectiveness of sanctions, and increase drivers' accountability through comprehensive and integrated measures.

Keywords: *Traffic rule violations, Law on Offenses, Administrative Law, statistical data on traffic rule violations.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Шинээр бүртгэгдсэн жолоочийн тоон үзүүлэлт	19
Хүснэгт 2. Замын хөдөлгөөний зөрчлийн мэдээлэл.....	19
Хүснэгт 3. Замын хөдөлгөөний зөрчлийн мэдээлэл. (Дүүргээр)	20
Хүснэгт 4. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ машин барьсан тохиолдол	21
Хүснэгт 5. 2020-2025 оны торгуулсан жолоочийн мэдээлэл	22
Хүснэгт 6. 2020-2025 оны эрхээ хасуулсан жолоочийн мэдээлэл	22
Хүснэгт 7. 2020-2025 оны баривчлагдсан жолоочдын мэдээлэл	23
Хүснэгт 8. 2023 онд хамгийн их давтагдсан зөрчлийн мэдээлэл.....	23
Хүснэгт 9. 2024 онд хамгийн их давтагдсан зөрчлийн мэдээлэл.....	24
Хүснэгт 10. 2025 онд хамгийн их давтагдсан зөрчлийн мэдээлэл.....	25
Хүснэгт 11. 2020-2025 онд гарсан зам тээврийн ослын мэдээлэл	26
Хүснэгт 12. 2023-2025 онд жолоочоос шалтгаасан буруутай үйлдлийн төрлүүд.....	27

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Улаанбаатар хотод ашиглаж буй ухаалаг камерын чиглэл.....	16
Зураг 2. Ухаалаг камераар илрүүлж буй зөрчлийн мэдээлэл.....	17
Зураг 3. Ухаалаг камерын ажиллаж буй байдал.....	17
Зураг 4 Асуулт 1. Судалгаанд оролцогчдийн нас.....	36
Зураг 5 Асуулт 2. Судалгаанд оролцогчдийн хүйс	36
Зураг 6 Асуулт 3. Судалгаанд оролцогчдийн боловсрол.....	36
Зураг 7 Асуулт 4. Судалгаанд оролцогчдын амьдардаг дүүрэг	37
Зураг 8 Асуулт 5. Та жолооч болоод хэдэн жил болж байгаа вэ?	37
Зураг 9 Асуулт 6. Та тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд ямар давтамжтай оролцдог вэ?	37
Зураг 10 Асуулт 7. Та ихэвчлэн ямар зорилгоор тээврийн хэрэгсэл жолооддог вэ?	37
Зураг 11 Асуулт 8. Та өөрийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг үнэлнэ үү.....	38
Зураг 12 Асуулт 9. Та замын хөдөлгөөн зөрчиж байсан эсэх.	38
Зураг 13 Асуулт 10. Хэрэв тийм бол ямар дүрэм зөрчиж байсан бэ?	38
Зураг 14 Асуулт 11. Таны хувьд жолооч нарыг замын хөдөлгөөний дүрэм зөрчихөд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийг сонгоно уу?.....	38
Зураг 15 Асуулт 12. Та ямар хүчин зүйлсийн улмаас замын хөдөлгөөний дүрмийг зөрчдөг вэ?	39
Зураг 16 Асуулт 13. Та замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагын талаар хэр сайн мэдэх вэ? (1-5 оноо: 1=мэдэхгүй, 5= маш сайн мэднэ)	39
Зураг 17 Асуулт 14. Таны бодлоор одоо мөрдөгдөж буй торгуулах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1–5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=Маш үр нөлөөтэй)	39
Зураг 18 Асуулт 15. Таны бодлоор одоо мөрдөж буй жолоодох эрх хасах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1–5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=маш үр нөлөөтэй).....	39
Зураг 19 Асуулт 16. Таны бодлоор одоо мөрдөгдөж буй баривчлах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1–5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=маш үр нөлөөтэй)	40

Зураг 20 Асуулт 17. Дараах зөрчлийн шийдвэрлэлтүүдээс аль нь жолоочид дахин зөрчил үйлдэхгүй байхад нөлөөлдөг гэж та үзэж байна вэ?.....	40
Зураг 21 Асуулт 18. Таны бодлоор замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад аль арга хэмжээ хамгийн үр дүнтэй вэ?	40
Зураг 22 Асуулт 21. Ухаалаг камерын системийн зөрчил илрүүлэлт болон торгууль ногдуулдаг журмын талаар мэдээлэл хангалттай авч чадаж байна уу?	41
Зураг 23 Асуулт 22. Ухаалаг камер, AI хяналттай үед та дүрэм зөрчихөөс илүү болгоомжилдог уу?.....	41
Зураг 24 Асуулт 23. Аль нь илүү үр дүнтэй гэж та үзэж байна вэ?	41

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Асуулгын судалгаа	60
Хавсралт 2 Судалгааны ярилцлагын удирдамж	63

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ТААС	Traffic Accident Analysis System буюу Зам тээврийн ослын дүн шинжилгээний систем
DUI	Driving Under the Influence буюу согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисын нөлөөн дор тээврийн хэрэгсэл жолоодох

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Сүүлийн жилүүдэд замын хөдөлгөөний дүрмийн зөрчил буурахгүй, харин тодорхой хэмжээгээр өсөх хандлагатай байгаа нь нийгмийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Тухайлбал, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдол байсан бол 2020 онд 1,580,126, 2021 онд 1,489,089 болж буурсан үзүүлэлттэй байсан ч 2022 оноос эрс өсөж 2,012,191, 2023 онд 2,146,107, 2024 онд 2,350,519, 2025 онд 3,870,150-д хүрсэн байна. Энэхүү өсөлт нь замын хөдөлгөөний аюулгүй байдал хангалтгүй байгааг илтгэхийн зэрэгцээ хэрэгжиж буй арга хэмжээний үр нөлөөг дахин авч үзэх шаардлагатайг харуулж байна. (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Нөгөө талаас Монгол Улсад бүртгэлтэй жолоочийн тоо жилээс жилд тогтвортой өсөж байгаа нь замын хөдөлгөөнд оролцогчдын тоо нэмэгдэж байгааг илтгэнэ. Тодруулбал, 2015 онд 1,038,624 байсан бол 2025 онд 1,652,020 болж өссөн байна. Жолоочийн тоо ийнхүү нэмэгдэж байгаа нь замын хөдөлгөөний ачаалал, эрсдэлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болох хэдий ч зөрчлийн тоо түүнээс илүү хурдацтай өсөж байгаа нь зөвхөн тоон өсөлтөөр тайлбарлагдахгүй, харин жолоочийн зан үйл, хяналтын тогтолцоо, хууль зүйн хариуцлагын үр нөлөөтэй шууд холбоотой байж болохыг харуулж байна. (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, нийгмийн хэвийн үйл ажиллагааг хангах суурь нөхцөл болдог. Гэвч бодит нөхцөл байдалд замын хөдөлгөөний зөрчил тогтмол гарч, зарим тохиолдолд хүний амь нас хохирсон ноцтой осол гарсаар байгаа нь энэ салбар дахь хууль эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн үр нөлөөг нарийвчлан судлах шаардлагатайг харуулж байна.

Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлага нь үндсэндээ торгууль ногдуулах, жолоодох эрх хасах, баривчлах гэсэн гурван төрлийн арга хэмжээгээр хэрэгжиж байна. Эдгээр арга хэмжээ нь зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох, дахин зөрчил гаргахаас сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах зорилготой боловч тэдгээрийн бодит үр нөлөө ямар түвшинд байгааг нарийвчлан судлах шаардлага байна. Ялангуяа торгуулийн арга хэмжээ нь өргөн хэрэглэгддэг боловч зарим жолоочийн хувьд зөрчлийг давтан гаргахаас сэргийлэх хангалттай нөлөө үзүүлэхгүй байх тохиолдол ажиглагдаж байна.

Мөн жолоодох эрх хасах болон баривчлах зэрэг илүү хатуу арга хэмжээнүүд нь тодорхой үр нөлөө үзүүлдэг ч тэдгээрийн хэрэгжилт, хэрэглээний давтамж, бодит нөлөөлөл нь харилцан адилгүй байна. Энэ нь хууль зүйн хариуцлагын тогтолцоо нь зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд бус, түүний хэрэгжилт, хяналт, шийдвэр гүйцэтгэлийн чанартай шууд холбоотой болохыг харуулж байна.

Нөгөө талаас замын хөдөлгөөний зөрчил нь зөвхөн хууль эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй, харин хүний зан үйл, нийгмийн ухамсар, замын хөдөлгөөний соёл, хяналтын тогтолцоо зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг цогц асуудал юм. Жолооч нарын дүрэм сахих хандлага сул, замын хөдөлгөөний соёл хангалтгүй, мөн хяналт,

шалгалтын тогтолцоо бүрэн төгс бус байгаа нь зөрчлийг бууруулахад саад болж байна. Иймд зөвхөн шийтгэлийг нэмэгдүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй бөгөөд цогц хандлага шаардлагатай байна.

Гадаадын улс орнуудын туршлагаас харахад замын хөдөлгөөний зөрчлийг бууруулахад хууль зүйн хариуцлагын оновчтой зохицуулалт, шаталсан шийтгэлийн тогтолцоо, тогтвортой бөгөөд шударга хэрэгжилт, мөн технологид суурилсан хяналтын систем чухал нөлөө үзүүлдэг байна. Тухайлбал, онооны систем, автомат хяналтын камер, давтан зөрчилд илүү хатуу шийтгэл ногдуулах зэрэг арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлснээр зам тээврийн осол, зөрчлийг бууруулж чадсан туршлага байна.

Иймээс Монгол улсад хэрэгжиж буй замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөөг бодитой үнэлэх, түүний сул болон давуу талыг тодорхойлох, цаашид боловсронгуй болгох боломжийг судлах шаардлага үүсч байна. Энэхүү судалгаа нь онолын төдийгүй практик ач холбогдолтой бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, зөрчлийг бууруулахад чиглэсэн бодлого, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх боломжтой юм. Түүнчлэн торгууль, жолоодох эрх хасах, баривчлах зэрэг арга хэмжээний харьцангуй үр нөлөөг тодорхойлох замаар илүү оновчтой, үр дүнтэй зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн шинжлэх ухааны үндэслэл бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Иймд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөөг судлах нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, судлах зайлшгүй шаардлагатай асуудал гэж үзэж байна.

Судлагдсан байдал

Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт, түүний үр нөлөөг судлах нь олон улсын хэмжээнд өргөн хүрээнд судлагдсан бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын чухал чиглэлд хамаардаг. Судлаачид энэхүү асуудлыг авч үзэхдээ зөвхөн шийтгэлийн төрлөөр хязгаарлахгүйгээр, түүний хэрэгжилтийн байдал, хяналтын тогтолцоо, мөн жолоочийн зан төлөвт үзүүлэх нөлөөллийг цогцоор нь авч үзэх хандлагатай байна.

Сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаануудын үр дүнгээс харахад замын хөдөлгөөний зөрчилд хүлээлгэх хариуцлагын үр нөлөө нь зөвхөн шийтгэлийн хатуу байдлаас бус, харин түүний хэрэгжилтийн үр ашиг, хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалтай нягт холбоотой болох нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалт хангалттай байхаас гадна түүнийг бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлж байгаа нь илүү чухал хүчин зүйл болдог байна.

Тухайлбал, Hosseini, Teymoor, Abroodi Mojtaba, Kashfi Saeid нарын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Тегеран хотын жишээн дээр хийсэн “Замын хөдөлгөөний зөрчлийн тухай шинэ хуулийн сэргийлэх нөлөө болон зам тээврийн осол, зөрчлийг бууруулахад үзүүлэх үр нөлөөний судалгаа” нь энэ чиглэлд хийгдсэн чухал судалгаанд тооцогддог. Тус судалгаанд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөөг үнэлж, шийтгэлийн төрөл болон хэрэгжилт нь жолоочийн зан үйл, зам тээврийн осолд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлсон байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд замын хөдөлгөөний зөрчилд оногдуулж буй шийтгэл нь тодорхой хэмжээнд үр нөлөөтэй боловч түүний нөлөө нь шийтгэлийн хатуу байдал болон хэрэгжилтийн түвшнээс шууд хамаарч байгааг тогтоосон. Ялангуяа онооны систем болон шаталсан шийтгэлийн арга хэмжээ нь зөрчил болон зам тээврийн ослыг бууруулахад илүү үр дүнтэй байгааг онцолсон байна. Харин зөвхөн торгууль зэрэг санхүүгийн шийтгэл нь дангаараа хангалттай үр нөлөө үзүүлэхгүй бөгөөд хяналт, илрүүлэлтийн түвшин, хууль хэрэгжилтийн тогтвортой байдал чухал нөлөөтэй гэж дүгнэжээ. (Abroodi, Kashfi, & Hosseini, 2018)

Мөн Omar Bouattane, El Mehdi Ben Laoula, Omar Elfahim, Marounane El Midaoui, Mohamed Youssfi нарын 2023 оны 9 дүгээр сард хийсэн “Замын хөдөлгөөний зөрчлийн шинжилгээ: Эрсдэлтэй бүсүүд болон түгээмэл зөрчлийг тодорхойлох нь” судалгаанд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн хууль, бодлогын арга хэмжээний үр нөлөөг үнэлсэн байна. Уг судалгаанд зам тээврийн осол, гэмтэл, нас баралтын үзүүлэлтүүдийг харьцуулан шинжилсний үндсэн дээр дүгнэлт хийсэн бөгөөд хатуу зохицуулалт, хяналтын арга хэмжээнүүд хэрэгжсэнээр ослын улмаас үүсэх хохирол буурах хандлага ажиглагдсан болохыг тогтоосон. Гэсэн хэдий ч эдгээр арга хэмжээний үр нөлөө нь зөвхөн хууль тогтоомжийн агуулгаас гадна түүний хэрэгжилт, хяналтын тогтолцоо, иргэдийн хууль сахих байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байгааг онцолсон байна. (El Mehdi Ben Laoula, 2023)

Дээрх судалгаануудыг нэгтгэн авч үзэхэд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хариуцлагын үр нөлөө нь зөвхөн шийтгэлийн төрлөөс бус, харин түүний хэрэгжилтийн чанар, хяналтын тогтолцоо, мөн шийтгэлийн арга хэмжээний уялдаа холбооноос ихээхэн хамааралтай болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, торгууль, жолоодох эрх хасах, баривчлах зэрэг арга хэмжээг тус тусад нь хэрэгжүүлэхээс илүүтэйгээр тэдгээрийг цогцоор нь, шаталсан байдлаар хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэх үндэслэл бүрдэж байна.

Монгол улсын хувьд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт нь Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудаар зохицуулагдаж байгаа бөгөөд торгууль, жолоодох эрх хасах, баривчлах гэсэн үндсэн гурван хэлбэрийг хэрэглэж байна. Энэхүү зохицуулалт нь олон улсын жишигтэй тодорхой хэмжээнд нийцэж байгаа боловч хэрэгжилтийн үр нөлөө, хяналтын тогтолцооны үр ашиг, бодит үр дүнгийн талаарх судалгаа харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна.

Дотоодын судалгаануудын хувьд замын хөдөлгөөний зөрчил, түүний шалтгаан, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар тодорхой хэмжээнд судалсан боловч хариуцлагын эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг гадаадын судалгаатай харьцуулан, цогцоор нь авч үзсэн судалгаа төдийлөн хангалтгүй байна. Ялангуяа шийтгэлийн хэрэгжилтийн бодит байдал, хяналтын үр нөлөө, жолоочийн зан төлөвт үзүүлэх нөлөөллийг нэгтгэн судлах шаардлага байсаар байна.

Иймд Монгол улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд оногдуулж буй хариуцлагын эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илүү нарийвчлан судалж, гадаадын туршлага, судалгааны үр дүнтэй харьцуулан дүн шинжилгээ хийх нь зүйтэй бөгөөд энэ

нь замын хөдөлгөөний зөрчлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах бодлогыг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэж буй эрх зүйн хариуцлагын тогтолцоог онол, эрх зүйн зохицуулалт болон практик хэрэглээний түвшинд шинжилж, түүний үр нөлөө, сул тал, цаашдын сайжруулах боломжийг тодорхойлоход оршино.

Судалгааны зорилт

1. Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох
2. АНУ, БНСУ болон Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх эрх зүйн хариуцлагын зохицуулалтыг харьцуулан судалж, онцлог, ялгааг тодорхойлох.
3. Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөөг судалж, сайжруулах боломжийг тодорхойлох

Судалгааны таамаглал

Таамаглал 1: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн зохицуулалт буюу зөрчлийн хуулиар торгох, эрх хасах, баривчлах нь замын хөдөлгөөнд оролцож буй жолоочийг зөрчил үйлдэхээс сэргийлж чадаж байгаа.

Таамаглал 2: Одоо хэрэгжиж буй торгох, эрх хасах, баривчлах зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

Таамаглал 3: Ухаалаг камерын систем ашиглан замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг багасгахад чухал ач холбогдолтой.

Судалгааны объект

Энэхүү судалгааны объект нь зээлийн гэрээний хугацааг сунгахтай холбоотой иргэний эрх зүйн харилцаа юм.

Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь хугацааг сунгах байдлаар хэт өндөр хүү тогтоосон зээлийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын иргэний эрх зүйн хүрээнд судална. Судалгааны хүрээнд зээлийн гэрээ, гэрээний эрх чөлөө, хүчин төгөлдөр бус хэлцэл, зан суртахууны хэм хэмжээг хамруулан авч үзэх бөгөөд хугацааг сунгалтын үр дүнд бий болсон хэт өрийн дарамтыг гадаадын зарим улсын туршлага, хандлагатай харьцуулан шинжилнэ.

Судалгааны шинэлэг байдал

Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх эрх зүйн хариуцлагын үр нөлөөг цогцоор нь судалсан судалгааны ажил харьцангуй хязгаарлагдмал байдаг. Иймд энэхүү судалгаа нь уг асуудлыг системтэйгээр авч үзсэнээрээ шинэлэг ач холбогдолтой юм.

Тус судалгаанд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэж буй эрх зүйн хариуцлагын зохицуулалтыг зөвхөн хууль зүйн хүрээнд бус, бодит хэрэгжилт болон олон нийтийн хандлагатай уялдуулан судалсан. Мөн Монгол Улсын зохицуулалтыг АНУ, БНСУ-ын туршлагатай харьцуулан шинжилж, онцлог, ялгааг тодорхойлсон.

Түүнчлэн замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг жолооч нараас, харин эрх зүйн хариуцлагын үр нөлөөг цагдаа алба хаагчдаас авсан асуулгын судалгаанд тулгуурлан хоёр өөр оролцогчийн байр суурийг харьцуулан авч үзсэн нь энэхүү судалгааны онцлог юм

БҮЛЭГ 1. ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ, ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРМИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ БА МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1 Захиргааны эрх зүйн тухай

Захиргааны эрх зүй гэдэг нь төрийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад үүсэх нийгмийн харилцааг зохицуулах зорилготой эрх зүйн хэм хэмжээнүүдийн нэгдсэн цогц юм. Энэ нь захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаа, түүний хэрэгжилт, түүнчлэн захиргааны байгууллага болон иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг хамарч, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгдөг онцлогтой. (П.Одгэрэл, 2008)

Захиргаа нь нийгмийн бүх салбарт өргөн хүрээг хамарч үйл ажиллагаа явуулдаг тул эдгээр салбарт үүсэх захиргаатай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээ өргөнөөр бий болдог. Үүний улмаас хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн ихэнх хэсэг захиргааны эрх зүйн зохицуулалтад хамаарч, энэ нь уг салбарыг бусад эрх зүйн салбараас ялгахын зэрэгцээ хамгийн өргөн хүрээтэй, төвөгтэй салбарын нэг болгодог. Мөн захиргааны эрх зүй нь нийгмийн хөгжил, хувьсалтай уялдан тасралтгүй шинэчлэгдэж, тулгамдсан асуудлыг үр нөлөөтэй шийдвэрлэх, эрх зүйн хийдэл, зөрчил багатай цогц тогтолцоог бүрдүүлэх шаардлагыг агуулж байдаг. (П.Одгэрэл, 2008)

Нийгэмд дэг журам, хэв журмыг хангах үндсэн чиг үүргийг захиргаа хэрэгжүүлдэг бөгөөд хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэд иргэн, хуулийн этгээдийн зүгээс хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьдаг. Энэ хүрээнд зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь захиргааны үйл ажиллагааны чухал хэсэг болдог. Тухайлбал, цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдал, иргэдийн амар тайван байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг онцлогтой. (П.Одгэрэл, 2008)

Захиргааны үйл ажиллагааны үндсэн зорилт нь нийтийн ашиг сонирхлыг хангахад чиглэдэг бөгөөд энэ нь нийгмийн сайн сайхан байдлаас урган гарсан шаардлага, хэрэгцээг тусган хэрэгжүүлэхтэй нягт холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл, захиргаа нь олон нийтийн эрх ашиг, аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахтай холбоотой асуудалд онцгой ач холбогдол өгч, тэдгээрийг хамгаалах, дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг онцлогтой. (П.Одгэрэл, 2008)

1.1.1 Захиргааны шийдвэр гаргах тухай ойлголт:

Захиргааны үйл ажиллагаа гэдэг нь захиргааны байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцдаа хуульд заасан боломжит хэлбэрүүдээс сонгон, тухайн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэр гаргах үйл явцыг хэлнэ. Энэ хүрээнд захиргааны шийдвэр гаргах ажиллагаа нь тодорхой дараалал бүхий үе шаттайгаар хэрэгждэг бөгөөд асуудлыг тодорхойлох, боломжит хувилбаруудыг үнэлж оновчтой сонголт хийх, шийдвэрийн төсөл боловсруулж баталгаажуулах, улмаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үндсэн дөрвөн үе шатыг дамжин хэрэгждэгээрээ тодорхойлогддог. (Амарсанаа, 2024)

Захиргааны байгууллага нь шийдвэр гаргах үйл ажиллагааны хүрээнд тухайн асуудалтай холбоотой бодит нөхцөл байдлыг тодорхойлон тогтоох шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, захиргааны шийдвэр гаргахдаа тухайн шийдвэрт нөлөөлөх үйл явдал, бодит нөхцөл байдлыг нарийвчлан судалж, үнэн зөв тогтоох нь зайлшгүй чухал юм. Ийнхүү бодит нөхцөл байдлыг бүрэн тогтоосноор боломжит хувилбаруудыг ялган таних, үндэслэлтэй дүгнэлт хийх, улмаар оновчтой, зөв шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой байдаг. (Амарсанаа, 2024)

1.1.2 Зөрчлийн захиргааны журмаар шийдвэрлэх:

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

Торгох шийтгэл:

Эрүүгийн шинжгүй, захиргааны зөрчилд хүлээлгэх эрх зүйн хариуцлага нь ихэвчлэн тухайн этгээдийн үйлдэлд шууд хорих, баривчлах зэрэг хүний үндсэн эрх, эрх чөлөөнд ноцтойгоор халдах үр дагавар үүсгэдэггүйгээрээ онцлогтой. Монгол Улсад түгээмэл тохиолдож буй захиргааны зөрчлүүдийн хувьд тэдгээрийн эрх зүйн үр дагавар нь гол төлөв торгууль ногдуулах хэлбэрээр илэрч, эрүүгийн хариуцлагын адил хатуу шинж чанартай арга хэмжээ дагуулах нь харьцангуй бага байдаг. (Б.Ганболд, 2018)

Хэдийгээр захиргааны торгууль болон эрүүгийн хуульд заасан торгох ял нь гадаад хэлбэрийн хувьд адил буюу мөнгөн төлбөр ногдуулах байдлаар илэрдэг ч тэдгээрийн зорилго, эрх зүйн мөн чанар нь харилцан ялгаатай юм. Эрүүгийн хуульд заасан торгох ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулах, шийтгэх шинж давамгайлсан агуулгатай байдаг бол захиргааны хариуцлагын хүрээнд ногдуулах торгууль нь урьдчилан сэргийлэх, дахин зөрчил үйлдэхээс хамгаалах, түүнчлэн хууль тогтоомж зөрчиж ашиг хүртэх хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгыг илүүтэй агуулдаг. (Б.Ганболд, 2018)

Торгох шийтгэл нь шүүх болон эрх бүхий албан тушаалтнаас зөрчил үйлдсэн этгээдэд мөнгөн төлбөр оногдуулах арга хэмжээ юм. Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй, харин хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоогддог. Энд нэг торгуулийн нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцэхээр хуульчилсан байна. (Амарсанаа, 2024)

Иймд захиргааны журмаар торгуулийн хариуцлага хүлээсэн этгээд нь эрүүгийн эрх зүйн хүрээнд ял эдэлсэнтэй адилтгах эрх зүйн үр дагавартай тулгардаггүй бөгөөд түүний эрх зүйн байдал нь гэмт хэрэг үйлдсэн этгээдээс ялгаатайгаар үнэлэгддэг онцлогтой гэж үзэж болно.

Баривчлах шийтгэл:

Баривчлах шийтгэл нь зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулах арга хэмжээ бөгөөд тодорхой этгээдэд оногдуулахыг хориглодог. Тухайлбал, жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн болон эрүүл мэндийн шалтгаанаар саатуулах боломжгүй этгээдэд энэхүү шийтгэлийг оногдуулахгүй.

Мөн баривчлах шийтгэлтэй холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүх бус, эрүүгийн хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр зохицуулсан байдаг. (Амарсанаа, 2024)

Эрх хасах шийтгэл:

Эрх хасах шийтгэл нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрх, эсхүл бусад тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл олгогдсон зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ юм. Энэ нь тухайн этгээдийн тодорхой үйл ажиллагаа эрхлэх боломжийг хугацаагаар хязгаарлах замаар хариуцлага хүлээлгэх хэлбэрээр илэрдэг. (Амарсанаа, 2024)

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь тусгайлан олгогдсон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль болон захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг зөрчсөн тохиолдолд тодорхой нөхцөл бүрдсэн үед эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэлд нэмэлт байдлаар оногдуулдаг. Тодруулбал, тухайн этгээд дээрх журмыг байнга буюу давтан зөрчсөн, эсхүл ноцтойгоор зөрчсөн, мөн өмнө нь оногдуулсан шийтгэлийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол эрх хасах арга хэмжээг хэрэглэх эрх зүйн үндэслэл бүрдэнэ. (Б.Ганболд, 2018)

Энд “байнга зөрчих” гэдэгт гурав ба түүнээс дээш удаагийн давтамжтай үйлдэл хамаарах бөгөөд “ноцтой зөрчил” гэдэг нь хүн, хуулийн этгээд, төр болон нийтийн эрх ашигт нөхөж баршгүй хохирол учруулсан, эсхүл тийм хор уршиг үүсэх шууд аюултай нөхцөл байдлыг бий болгосон, түүнчлэн их хэмжээний бодит хохиролд хүргэсэн үйлдлийг ойлгоно. Харин “шийтгэл биелүүлэхээс зайлсхийсэн” нөхцөлийг өмнө нь оногдуулсан шийтгэлтэй холбон авч үзэх бөгөөд тухайн этгээд уг шийтгэлийг хэрэгжүүлэхээс санаатайгаар татгалзсан, биелүүлэхгүй байх үйлдэл гаргасан тохиолдлыг хамруулна. (Б.Ганболд, 2018)

Ийм байдлаар дээрх гурван нөхцөл буюу давтамж (байнга), хор уршгийн ноцтой байдал (ноцтой), мөн шийтгэлээс зайлсхийсэн байдал (зайлсхийсэн) зэрэг шалгуур хангагдсан үед эрх хасах шийтгэлийг нэмэлт байдлаар хэрэглэх боломжтой гэж үзнэ. (Б.Ганболд, 2018)

Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл:

Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл нь торгох шийтгэлийг биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрээр цалин, хөлс олгохгүйгээр олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн ажил гүйцэтгүүлэх арга хэмжээ юм. Уг шийтгэлийн хүрээнд өдөрт наймаас илүүгүй цаг ажиллуулах бөгөөд нийт хугацааг хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтоодог. Түүнчлэн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд энэхүү шийтгэлийг оногдуулахгүй байхаар хуульчилсан байна (Амарсанаа, 2024).

Ийнхүү захиргааны эрх зүй нь нийгмийн дэг журам, нийтийн ашиг сонирхлыг хангах үндсэн хэрэгсэл болохын хувьд зөрчлийн эрх зүйн зохицуулалтаар дамжуулан замын хөдөлгөөний харилцааг зохицуулах чухал үүргийг гүйцэтгэж байна. Тодруулбал, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8.2.4-т холбогдох хуульд заасны дагуу Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулахыг хуульчилсан бөгөөд энэ нь Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “зөрчил үйлдсэн хүн,

хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулна” гэсэн зохицуулалттай уялдаж байна. Үүний зэрэгцээ Зөрчлийн тухай хуулийн арван дөрөвдүгээр бүлгийн 14.7 дугаар зүйлд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчихтэй холбоотой зөрчлүүдийг тусгайлан зохицуулж, тэдгээрт захиргааны шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалтын нэгдмэл, уялдаа бүхий тогтолцоог бүрдүүлсэн байна. Иймд замын хөдөлгөөний зөрчлийг захиргааны эрх зүйн хүрээнд тусгай болон ерөнхий хуулийн зохицуулалтын уялдаанд үндэслэн цогцоор нь зохицуулж, нийгмийн аюулгүй байдал, хэв журмыг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт хэрэгжиж байна.

1.2 Замын хөдөлгөөний дүрмийн тухай ойлголт

Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн зорилго нь улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний нэгдсэн журам тогтооход оршдог. Замын хөдөлгөөнийг эрх зүйн хүрээнд зохицуулах анхны оролдлого нь 1925 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хийгдсэн гэж үздэг. Тодруулбал, тухайн өдөр “Аливаа гал усны уурын хүчээр явах тэрэг зэргийг БНМАУ-ын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрэм” нэртэйгээр замын хөдөлгөөнийг зохицуулах анхны эрх зүйн баримт бичгийг баталсан байна. Энэхүү дүрэм нь нийт 21 зүйл, ангитай байсан бөгөөд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, техник технологийн хөгжлийн түвшинд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах зорилготой байжээ. (Тээврийн цагдаагийн алба, 2023)

Ийнхүү замын хөдөлгөөний зохицуулалт нь анхнаасаа эрх зүйн хүрээнд бий болж, улмаар цаг хугацааны явцад нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн улам боловсронгуй болсоор ирсэн түүхтэй юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түүнтэй холбоотой нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмээр тодорхойлсон байдаг. Тус хууль болон дүрмийн зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, энэ хүрээнд үүсэх харилцааг зохицуулахад оршино. (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, огноо байхгүй)

Замын хөдөлгөөний тухай ойлголтыг зөвхөн тээврийн хэрэгслийн зам дээрх хөдөлгөөнөөр хязгаарлан ойлгох нь учир дутагдалтай бөгөөд энэ нь илүү өргөн хүрээтэй, олон талт агуулгатай ойлголт юм. Өөрөөр хэлбэл, замын хөдөлгөөн нь зам, тээврийн хэрэгсэл, жолооч, явган зорчигч болон бусад оролцогчдын хооронд үүсэх харилцан уялдаатай, тасралтгүй үйл явц бөгөөд эдгээрийн аюулгүй байдлыг хангах нь уг ойлголтын гол зорилго болдог.

Түүнчлэн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн хувь хүний үүрэг бус, төрийн бодлого, зохицуулалтын хүрээнд авч үзсэн байдаг. Энэ нь замын хөдөлгөөний аюулгүй байдал нь нийгмийн нийтлэг ашиг сонирхолд хамаарах, нийтийн эрх зүйн шинжтэй харилцаа болохыг илтгэнэ. Иймээс төрөөс замын хөдөлгөөний зохион байгуулалт, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх замаар иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байдаг.

Нөгөө талаас, замын хөдөлгөөний дүрмээр замын хөдөлгөөнд оролцогч бүр тодорхой эрх, үүрэгтэй оролцдог. Жолооч нь тээврийн хэрэгслийг аюулгүй жолоодох, замын хөдөлгөөний дүрмийг сахих үүрэгтэй бол явган зорчигч нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй. Энэ хүрээнд замын хөдөлгөөн нь зөвхөн техникийн бус, хүний зан үйл, хандлага, сахилга баттай шууд холбоотой нийгмийн үзэгдэл юм.

Иймд замын хөдөлгөөний тухай ойлголтыг дараах байдлаар нэгтгэн дүгнэж болно. Үүнд: замын хөдөлгөөн гэдэг нь зам, тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөнд оролцогчдын харилцан үйлчлэлд тулгуурласан, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах зорилготой, эрх зүйн зохицуулалт бүхий нийгмийн цогц харилцаа юм.

1.3 AI буюу ухаалаг камерийн системийн тухай ойлголт

Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаанд суурилсан замын хөдөлгөөний хяналтын технологи эрчимтэй хөгжиж, түүний нэг жишээ нь AI хурд хэмжигч болон зөрчил илрүүлэх камерууд юм. Эдгээр камерууд нь уламжлалт хурд хэмжигч төхөөрөмжүүдээс илүү дэвшилтэт бөгөөд зөвхөн хурд хэтрүүлэхийг бус, жолоочийн гар утас ашиглах, хамгаалах бүс зүүхгүй байх, урд явж буй тээврийн хэрэгсэлтэй хэт ойр зай барих зэрэг олон төрлийн зөрчлийг илрүүлэх боломжтой болсон байна. (INSHUR, 2025)

AI камер нь өндөр нягтралтай дүрс, видео мэдээллийг бодит цаг хугацаанд цуглуулж, машин сургалтын алгоритмаар боловсруулан зөрчлийг автоматаар таньж илрүүлдэг. Мөн автомашины улсын дугаарыг таних системтэй хослон ажилласнаар тухайн зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг мэдээллийн сантай холбон шууд илрүүлэх боломж бүрддэг. Үүний үр дүнд зөрчлийг баримтжуулах, нотлох үйл явц илүү нарийвчлалтай, үр ашигтай болж байна. (INSHUR, 2025)

Ийм төрлийн технологийг ашиглах гол зорилго нь зам тээврийн осол, нас баралтын гол шалтгаан болдог хурд хэтрүүлэлт, анхаарал сарнилттай жолоодлогыг бууруулахад мөн хүний нүдээр хянах боломж хязгаарлагдмал байдаг хэсгийг AI систем нь тасралтгүй, алдаагүй хяналт хийх боломжийг бүрдүүлдэг. Жишээ нь: AI камерууд нь цаг агаарын таагүй нөхцөл, харагдах орчин муу үед ч үр дүнтэй ажиллах чадвартай бөгөөд олон эгнээг зэрэг хянах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нарийвчлан шинжлэх боломжтой. (INSHUR, 2025)

Мөн бодит жишээнүүдээс харахад AI камер нь жолоочийн гар утас ашиглах, зай барихгүй явах зэрэг зөрчлийг маш тодорхой баримтжуулж, маргаангүй нотлох боломжийг бүрдүүлдэг. Энэ нь жолооч нарт хариуцлага тооцохоос гадна тэдний зан үйлд нөлөөлж, дүрэм сахих хандлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. (INSHUR, 2025)

Бүлгийн дүгнэлт

Дээрхээс дүгнэж үзэхэд захиргааны журмаар зөрчил шийдвэрлэх тогтолцоо нь нийгмийн дэг журам, нийтийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн чухал эрх зүйн механизм болж байна. Тухайлбал, торгох, баривчлах, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг шийтгэлүүд нь зөрчлийн шинж, хор уршгийн түвшинд тохируулан оногдуулдаг бөгөөд энэ нь зөрчилд хүлээлгэх хариуцлагын уян хатан, шаталсан тогтолцоог бүрдүүлж байна. Ялангуяа торгох шийтгэл нь өргөн хэрэглэгддэг бөгөөд

урьдчилан сэргийлэх, дахин зөрчил үйлдэхээс сэргийлэх гол хэрэгсэл болж байгаа бол эрх хасах болон баривчлах шийтгэл нь илүү ноцтой, давтан шинжтэй зөрчилд чиглэсэн байна.

Замын хөдөлгөөний дүрэм, түүний эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсад түүхэн хөгжлийн явцад тасралтгүй боловсронгуй болж, өнөөдөр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуулийн уялдаа холбоонд тулгуурлан хэрэгжиж байна. Энэ нь замын хөдөлгөөнийг зөвхөн техникийн үйл ажиллагаа бус, харин олон оролцогчийн харилцан үйлчлэл бүхий нийгмийн цогц харилцаа болохыг илтгэнэ.

Түүнчлэн орчин үеийн технологийн хөгжил, ялангуяа хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын системүүд (AI камер) нэвтэрснээр замын хөдөлгөөний зөрчлийг илрүүлэх, баримтжуулах, хяналт тавих үйл ажиллагаа илүү үр ашигтай, тасралтгүй болж байна. Энэ нь хүний хүчин зүйлээс хамаарах сул талыг бууруулж, зөрчлийг бодит цаг хугацаанд илрүүлэх боломжийг бүрдүүлж байгаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлэх хандлагатай байна.

Иймд захиргааны хариуцлагын тогтолцоо болон орчин үеийн хяналтын технологийн хослол нь замын хөдөлгөөний зөрчлийг бууруулах, иргэдийн хууль сахих хандлагыг төлөвшүүлэх, цаашлаад нийгмийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл болж байна.

БҮЛЭГ 2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

2.1 Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал

Сүүлийн жилүүдэд замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийн асуудал нь нийгмийн анхаарал татсан чухал сэдвийн нэг болж байна. Хэдийгээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлж, зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгосон боловч бодит хэрэгжилтийн түвшин хангалттай хэмжээнд хүрэхгүй хэвээр байна. Энэ нь замын хөдөлгөөний зөрчил, ослын тоо буурахгүй байгаагаар илэрч байгаа бөгөөд хууль тогтоомжийн үр нөлөөг бодит байдалд үнэлэх шаардлагыг бий болгож байна.

Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жолоочид хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг хууль тогтоомжид системтэйгээр тусгасан байдаг. Энэ хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ерөнхий зохицуулалтыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль-д тодорхойлсон бол замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хэрэгжүүлэх журмыг Зөрчлийн тухай хууль-д нарийвчлан зохицуулсан байдаг.

Тодруулбал, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочид холбогдох хариуцлагыг оногдуулах талаар зохицуулсан бөгөөд энэ нь замын хөдөлгөөний зөрчлийг хууль зүйн хүрээнд шийдвэрлэх үндсэн зохицуулалтын нэг хэсэг болдог. Уг заалтын дагуу жолоочийн гаргасан зөрчлийн шинж, хор уршгийн хэмжээнээс хамааран хуульд заасан арга хэмжээг авдаг байна.

Зөрчлийн тухай хуулийн бүтцийн хувьд замын хөдөлгөөнтэй холбоотой зөрчлүүдийг тусгайлан авч үзсэн бөгөөд энэ нь тус хуулийн Арван дөрөвдүгээр бүлэг болох “Мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил”-д багтдаг. Уг бүлэг нь олон зүйл, заалтаас бүрдэх бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зөрчлүүдийг төрөлжүүлэн ангилж, тус бүрд нь хүлээлгэх хариуцлагын хэлбэр, хэмжээг нарийвчлан тогтоосон байдаг.

Тухайн бүлэгт хурд хэтрүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, замын тэмдэг, тэмдэглэгээ зөрчих, хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангаагүй үйлдэл гаргах зэрэг зөрчлүүдийг тус тусад нь авч үзэж, тэдгээрт оногдуулах торгууль, жолоодох эрх хасах, баривчлах зэрэг хариуцлагыг ялгамжтайгаар тогтоосон байна.

Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хариуцлага нь үндсэндээ торгууль ногдуулах, жолоодох эрх хасах, баривчлах гэсэн гурван үндсэн хэлбэртэй бөгөөд эдгээрийг зөрчлийн шинж чанар, давтан үйлдэл, учруулсан хор уршгаас хамааран шаталсан байдлаар хэрэглэдэг. Энэ нь хариуцлагын үр нөлөөг нэмэгдүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал механизм болдог.

Иймд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт нь нэг талаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар ерөнхий чиглэлээ тодорхойлж, нөгөө талаас Зөрчлийн тухай хуулиар нарийвчлан хэрэгждэг, харилцан уялдаатай эрх зүйн тогтолцоо бүрдүүлж байна гэж дүгнэж болно.

Зөрчлийн тухай хуульд заасан замын хөдөлгөөний зөрчилд дараах торгууль болон шийтгэлээр зохицуулагддаг болно.

- Жолоодох эрхгүй, эсхүл эрх дууссан жолооч
- Эрхгүй хүнд жолоо шилжүүлэх
- Согтууруулах ундаа, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн хүнд жолоо шилжүүлэх
- Согтуурсан, мансуурсан үедээ жолоодох
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй, ядарсан үедээ жолоодох
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй, ядарсан хүнээр жолоодуулах
- Бичиг баримтгүй жолоодох
- Бичиг баримтгүй жолоо шилжүүлэх
- Бүртгэлгүй, улсын үзлэгт ороогүй, тэнцээгүй тээврийн хэрэгсэл ашиглах
- Дугаар арилсан, бүдгэрсэн, бохир, буруу байрлуулсан
- Дугааргүй, эсхүл нуун далдалсан
- Хуурамч улсын дугаар ашиглах
- Тоормос, жолооны механизм ажиллахгүй, чиргүүлийн холбоос /чиргүүлтэй үед/ эвдэрсэн, эсхүл харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл нь бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон бол
- Ашиглахыг хориглосон бүрэн бус тээврийн хэрэгслээр ашиглах
- Хууль бус тусгай дохио суурилуулах
- Тусгай дохиотой машинд зам тавьж өгөхгүй байх
- Осол гаргаад зугтах
- Осол гаргасны дараах үүргээ биелүүлэхгүй байх
- Хамгаалалтын бүс хэрэглээгүй
- Зориулалтын Мото каск өмсөөгүй
- Жолоодох үед гар утас хэрэглэх
- Гэрлэн дохио зөрчих
- Дуут дохио буруу хэрэглэх
- Ослын дохио, тэмдэг буруу хэрэглэх
- Давуу эрхтэй тээврийн хэрэгсэлд зам тавьж өгөөгүй
- Эгнээ, байр өөрчлөх дүрэм зөрчих
- Хориглосон газар ухрах, буцаж эргэх
- Замын зорчих хэсгээс гадуур, дүрэм зөрчиж явах
- Урсгал сөрөх
- Хурд заасан хэмжээнээс 10–50% хэтрүүлэх
- Хурд заасан хэмжээнээс 50%-иас дээш хэтрүүлэх
- Огцом тоормослох, бусад тээврийн хэрэгсэлд саад учруулах

- Гүйцэж түрүүлэх журам зөрчих
 - Зогсоол, гарц дээр буруу зогсох
 - Хороололд хөдөлгөөний журам зөрчих
 - Бусад зогсоолын журам зөрчих
 - Явган зорчигчид зам тавьж өгөхгүй
 - Хориглосон газар гүйцэж түрүүлэх
 - Төмөр замын гарам зөрчих
 - Жолооч тээврийн хэрэгслийн холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлээгүй, эсхүл тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл хэрэглэх журам зөрчих
 - Тууш замын журам зөрчих
 - Жолоодлогын дадлагын багш замын хөдөлгөөний дүрэмд заасан дадлага хийх журам зөрчсөн
 - Чирэх журам зөрчих
 - Хүн тээвэрлэх журам зөрчих
 - Аюултай, хүнд ачаа зөрчиж тээвэрлэх
 - Бусад ачаа тээвэрлэлтийн зөрчил
 - Тэмдэг зөрчиж зүүн эргэх /буцах/
 - Жин, тэнхлэгийн хязгаар зөрчих
 - Бусад тэмдэг, тэмдэглэл зөрчих
 - Зөрчлөөр хохирол учруулах
 - Замын аюулгүй байдал хангах үүрэг зөрчих
 - Явган зорчигч дүрэм зөрчих
 - Эцэг, эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан арав хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулж замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргахад хүргэх
 - Эрхгүй, согтуу хүнээр жолоодуулахыг шаардах
 - Жолоочийн хөдөлмөр, амралтын горим зөрчих
 - Хөдөлгөөний хязгаарлалт зөрчих
 - Уулзвар нэвтрэх журам зөрчих
- Эх сурвалж:* (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, огноо байхгүй)

Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын зохицуулалтыг авч үзэхэд Монгол Улсад зөрчлийн төрөл, хэлбэр маш өргөн хүрээг хамарч байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, жолоочийн ёс зүй, сахилга баттай холбоотой (согтуугаар жолоодох, гар утас хэрэглэх, хурд хэтрүүлэх), техникийн бүрэн бүтэн байдалтай холбоотой (үзлэгт ороогүй тээврийн хэрэгсэл, эвдрэлтэй механизм), мөн хөдөлгөөний зохион байгуулалт, дүрмийн хэрэгжилттэй холбоотой (гэрлэн дохио зөрчих, урсгал сөрөх, давуу эрх олгохгүй байх) зэрэг олон төрлийн зөрчлүүдийг хуульчилсан байна. (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, огноо байхгүй)

Эдгээр зөрчилд оногдуулах хариуцлага нь зөрчлийн аюулын шинж чанар, хор уршгаас хамааран ялгамжтай тогтоогдсон бөгөөд хувь хүнд 10,000–400,000 төгрөгийн торгууль, хуулийн этгээдэд 100,000–1,000,000 төгрөгийн торгууль оногдуулахын зэрэгцээ жолоодох эрх хасах, баривчлах зэрэг нэмэлт арга хэмжээ хэрэглэж байна. Энэ

нь хууль тогтоогч зөрчлийн хүнд, хөнгөн байдлыг шаталсан байдлаар үнэлж, зохих хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн болохыг харуулж байна. (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, огноо байхгүй)

Түүнчлэн замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд оногдуулсан торгуулийг хуульд заасан хугацаанд сайн дураараа биелүүлсэн тохиолдолд шийтгэлийн хэмжээг 50 хүртэл хувиар хөнгөрүүлэх зохицуулалт нь зөрчил гаргасан этгээдийг торгуулиа шуурхай төлөхөд урамшуулах, улмаар шийтгэлийн биелэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн систем гэж үзэж байна.

2.1.2 Ai камер буюу ухаалаг камерын хяналт

Улаанбаатар хотод теле камер буюу ухаалаг камерын системийг найман чиглэлээр ашиглаж байна. Теле камерын нэгдсэн төв болон дүүрэг бүрт дэд төвүүдийг байгуулж, тэдгээрийг дэд бүтэц, удирдлага, хяналтын систем, программ хангамжаар бүрэн ханган ажиллуулж байна. Энэхүү систем нь гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх замаар нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилготой. (Замын хөдөлгөөний удирдлагын төв, 2026)

Нийслэлд бүртгэгдэж буй зөрчлийн дийлэнх буюу 80 гаруй хувь нь замын хөдөлгөөний дүрэм зөрчсөнтэй холбоотой тул авто замын уулзвар, гарцуудад камер суурилуулж, нэгдсэн төвөөс хяналт тавих болсон. Үүний үр дүнд жолооч нарыг дүрмээ мөрдөх, хөдөлгөөнд соёлтой оролцох нөхцөл сайжирч байна. (Замын хөдөлгөөний удирдлагын төв, 2026)

Мөн холбогдох байгууллагуудын уялдаа холбоог технологийн тусламжтайгаар бэхжүүлж, мэдээлэл солилцоог шуурхай болгосон. Орчин үеийн шийдэл, хиймэл оюун ухаанд суурилсан системийг нэвтрүүлснээр тээврийн хөдөлгөөнийг илүү үр дүнтэй удирдах, хянах боломж бүрдэж, иргэдийн цаг, зардлыг хэмнэх, тээврийн хэрэгслийн өсөлтөөс үүсэх сөрөг нөлөөг бууруулах нөхцөл бүрджээ. (Замын хөдөлгөөний удирдлагын төв, 2026)

Түүнчлэн ухаалаг камер, аналитик системийг ашиглан замын хөдөлгөөний зөрчлийг илрүүлэх, дата цуглуулах, замын хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулахад дэмжлэг үзүүлж байна. Энэ систем нь түгжрэлийг бууруулах, хууль зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бүтээн байгуулалт болон нийтийн аж ахуйг хянах, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, мөн гамшиг ослын үед шуурхай хариу арга хэмжээ авахад чухал ач холбогдолтой. (Замын хөдөлгөөний удирдлагын төв, 2026)

Зураг 1. Улаанбаатар хотод ашиглаж буй ухаалаг камерын чиглэл



Эх сурвалж: (Замын хөдөлгөөний удирдлагын төв, 2026) 2.1.2 Тусгай хуулийн зохицуулалт

2.1.2.1 AI камерт суурилсан замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх тогтолцоо

Хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг камераар замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх туршилтын үйл ажиллагаа 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэх ба торгууль ногдуулах зохицуулалт 2026 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Улаанбаатар хотын 176 уулзвар, гарц замд 2606 гаруй камерыг шинээр суурилуулж, замын хөдөлгөөнийг AI буюу хиймэл оюун ухаан ашиглан дараах зөрчилд зөрчлийн торгууль оногдуулна. (Тээврийн прокурорын газар, 2025) Үүнд:

AI камераар илрүүлэх зөрчлийн төрөл:

- тээврийн хэрэгсэл хурд хэтрүүлэх,
- гэрэл дохио зөрчих,
- нэгдүгээр эгнээгээр зорчих,
- эгнээ байр буруу эзлэх,
- автобусны буудал дээр зогсох,
- агшин зуурын хурд хэтрүүлэх,
- дундаж хурд хэтрүүлэх,
- "Зогс" шугам давах,
- түр буюу удаан хугацаагаар зогсох,
- явган хүний зам болон ногоон байгууламж дээр тээврийн хэрэгслийг байршуулах

Эх сурвалж: (Икон, 2026)

Тээврийн прокурорын газраас мэдээлснээр тус газрын харьяа Замын цагдаагийн газрын теле хяналт, замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс нь IREX буюу хиймэл оюун

ухаанд суурилсан дэлхийн 21 улс оронд ашиглагдаж буй системийг Улаанбаатар хотод хэрэгжүүлж байна. (Тээврийн прокурорын газар, 2025)

Зураг 2. Ухаалаг камераар илрүүлж буй зөрчлийн мэдээлэл



Эх сурвалж: (Тээврийн прокурорын газар, 2025)

Зураг 3. Ухаалаг камерын ажиллаж буй байдал



Эх сурвалж: (Тээврийн прокурорын газар, 2025)

2.1.2.2 IREX буюу Монгол улсад ашиглаж буй ухаалаг камерын систем

Энэхүү технологи нь камерын бичлэг дээр компьютер хараа ашиглан замын хөдөлгөөний нөхцөл байдлыг бодит цаг хугацаанд шинжилж, дүрэм зөрчсөн үйлдлийг автоматаар илрүүлэх боломжийг бүрдүүлдэг. Үүний үр дүнд уламжлалт гар ажиллагаанд тулгуурласан хяналтын аргаас ялгаатайгаар их хэмжээний мэдээллийг богино хугацаанд боловсруулж, хүний оролцоог багасгах давуу талтай болж байна. (IREX, 2026)

AI систем нь зөвхөн зөрчил илрүүлэхээс гадна замын хөдөлгөөний урсгалыг бүхэлд нь хянах, удирдах боломжийг олгодог. Тухайлбал, хотын зам, уулзвар, зогсоол зэрэг олон төрлийн орчныг нэг сүлжээнд холбон, аль хэсэгт зөрчил их гарч байгааг тодорхойлох, улмаар бодлогын түвшинд шийдвэр гаргахад ашиглах боломж бүрддэг. Энэ нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний ачааллыг зохицуулахад чухал ач холбогдолтой юм. (IREX, 2026)

Хиймэл оюун ухаанд суурилсан системүүд нь хурд хэтрүүлэх, улаан гэрэл зөрчих, эгнээ буруу ашиглах, хориглосон бүсэд нэвтрэх, зогсоолын дүрэм зөрчих зэрэг олон төрлийн зөрчлийг илрүүлэх чадвартай. Мөн автомашины улсын дугаар, өнгө, загварыг таних технологийг ашигласнаар тодорхой тээврийн хэрэгслийг хянах, давтан зөрчил гаргагчийг илрүүлэх боломжийг бүрдүүлдэг. Энэ нь хяналтын үр нөлөөг нэмэгдүүлж, зөрчил гаргагчдад хүлээлгэх хариуцлагын хэрэгжилтийг сайжруулах нөхцөл болдог. (IREX, 2026)


Гэсэн хэдий ч ийм төрлийн системийг нэвтрүүлэхэд зөвхөн технологийн шийдэл хангалтгүй бөгөөд хууль эрх зүйн зохицуулалт, мэдээллийн хамгаалалт чухал үүрэгтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор “governance-first” буюу бодлого, зохицуулалтыг нэгдүгээрт тавих хандлага түлхүү хэрэгжиж байна. Энэ хандлага нь зөвхөн шаардлагатай мэдээллийг цуглуулах, өгөгдөлд хандах эрхийг хязгаарлах, системийн үйл ажиллагааг ил тод, хяналттай байлгах зэрэг зарчмыг баримталдаг. Ингэснээр иргэдийн хувийн нууцыг хамгаалах, технологийн буруу хэрэглээнээс урьдчилан сэргийлэх боломжыг бүрдүүлдэг. (IREX, 2026)

2.1.3 Замын хөдөлгөөний зөрчлийн статистик мэдээлэл

2.1.3.1 Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн мэдээлэл

Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэлээс авч үзэхэд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдлын тоо сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай хэвээр байна. Тухайлбал, 2020 онд 1,580,126 зөрчил бүртгэгдэж байсан бол 2021 онд 1,489,089 болж бага зэрэг буурсан үзүүлэлт ажиглагдсан ч 2022 оноос эхлэн огцом өсөж, 2,012,191 болсон байна. Үүний дараа 2023 онд 2,146,107, 2024 онд 2,350,519 болж тасралтгүй нэмэгдсэн нь замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилт бодит байдал дээр хангалтгүй байгааг харуулж байна. Нөгөө талаас, Монгол Улсад бүртгэлтэй жолоочийн тоо мөн адил жилээс жилд өссөн бөгөөд 2020 онд 1,362,354 байсан бол 2025 онд 1,652,020 болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Шинээр бүртгэгдсэн жолоочийн тоон үзүүлэлт



Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Хүснэгт 2. Замын хөдөлгөөний зөрчлийн мэдээлэл.



Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Гэвч замын хөдөлгөөний дүрэм зөрчлийн өсөлтийг зөвхөн жолоочийн тооны нэмэгдэлтэй шууд холбон тайлбарлах нь учир дутагдалтай юм. Үүнд жолоочийн хууль сахих хандлага, замын хөдөлгөөний соёл, хяналт шалгалтын тогтолцооны үр нөлөө, шийтгэлийн бодит хэрэгжилт зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна. Ялангуяа замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд хариуцлага зайлшгүй оногдох байдал хангалтгүй, хяналтын арга хэмжээ тогтмол, жигд хэрэгжихгүй байгаа нь зөрчил буурахгүй байх үндсэн шалтгааны нэг гэж үзэж болно. Түүнчлэн зарим тохиолдолд торгуулийн арга хэмжээ нь зан үйлд бодит өөрчлөлт авчрах хэмжээнд хүрэхгүй, зөвхөн нэг удаагийн шийтгэл хэлбэрээр хэрэгжиж байгаа нь урьдчилан сэргийлэх үр нөлөөг сулруулж байна.

2020–2025 оны хооронд Улаанбаатар хотын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн илрүүлэлтийн статистик мэдээллийг авч

үзлээ. Дүн шинжилгээ хийхэд тухайн хугацаанд зөрчлийн илрүүлэлт тогтмол бус, тодорхой хэлбэлзэлтэй байгааг харуулж байна.

Тухайлбал, 2020 онд нийт 1,580,126, 2021 онд 1,489,089 зөрчил бүртгэгдсэн бол 2022 онд 222,402 болж огцом буурсан үзүүлэлттэй байна. Харин 2023 онд 686,550 болж дахин өсөх хандлага ажиглагдаж, 2024 онд 1,997,439, 2025 онд 3,709,315 хүрч, сүүлийн хоёр жилд илрүүлэлтийн хэмжээ эрчимтэй нэмэгдсэн байна. (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Хүснэгт 3. Замын хөдөлгөөний зөрчлийн мэдээлэл. (Дүүргээр)

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн илрүүлэлт - дүүргээр	2020	2021	2022	2023	2024	2025
Баянгол	233,230	247,735	25,674	90,581	67,026	160,173
Баянзүрх	204,896	310,112	15,331	139,535	1,485,349	185,198
Сүхбаатар	336,103	207,183	21,927	79,019	86,997	210,260
Сонгинохайрхан	183,250	202,126	34,331	78,611	85,998	186,241
Хан-Уул	169,802	230,301	15,471	79,266	81,216	190,798
Чингэлтэй	382,026	220,051	20,087	95,814	86,618	2,667,735
Багануур	24,834	26,648	46,058	42,831	34,639	32,614
Багахангай	11,008	11,252	24,899	24,099	20,805	19,827
Налайх	34,977	33,681	18,624	56,794	48,791	56,469

Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Улаанбаатар хотын хэмжээнд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн тоон үзүүлэлтийг 2020–2025 оны хооронд авч үзвэл тодорхой хэлбэлзэлтэй байна. Тухайлбал, 2020 онд 10,475 тохиолдол бүртгэгдсэн бол 2021 онд 18,010 болж өсөж, 2022 онд 30,323 хүрч хамгийн өндөр үзүүлэлтэд хүрсэн байна. Харин 2023 онд 20,706 болж буурсан бөгөөд 2024 онд 10,738 хүртэл эрс багассан байна. Гэсэн хэдий ч 2025 онд 11,501 болж бага зэрэг өссөн үзүүлэлт ажиглагдаж байна. Энэхүү өөрчлөлт нь хууль, хяналтын арга хэмжээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нөлөө, мөн жолооч нарын хариуцлагын түвшинтэй холбоотойгоор өөрчлөгдөж байж болох бөгөөд согтуугаар жолоо барих зөрчил нь цаг хугацааны хувьд тогтмол буурах хандлага хараахан тогтоогүй байгааг харуулж байна.

Хүснэгт 4. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ машин барьсан тохиолдол



Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд оногдуулсан шийтгэлийн тоон үзүүлэлтийг 2020–2025 оны хооронд авч үзвэл тодорхой хэлбэлзэлтэй байна. Тухайлбал, 2020 онд 2,028,325 зөрчилд шийтгэл оногдуулсан бол 2021 онд 1,425,865 болж буурсан байна. Харин 2022 онд 1,861,326 болж нэмэгдэж, 2023 онд 2,125,028, 2024 онд 2,338,744 болж өссөн үзүүлэлттэй байна. 2025 онд 3,856,252 хүрч өмнөх онуудаас хамгийн өндөр үзүүлэлтэд хүрсэн байна. Иймд дээрх хугацаанд зөрчлийн шийдвэрлэлтийн тоо буурах болон өсөх хэлбэлзэл ажиглагдсан бөгөөд сүүлийн жилүүдэд өсөх хандлага давамгайлж байна.

Хүснэгт 5. 2020-2025 оны торгуулсан жолоочийн мэдээлэл



Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан тоон үзүүлэлтийг 2020–2025 оны хооронд авч үзвэл тодорхой хэлбэлзэл ажиглагдаж байна. Тухайлбал, 2020 онд 21,591 хүн жолоодох эрхээ хасуулсан бол 2021 онд 17,035 болж буурсан байна. Харин 2022 онд 27,182 болж өсөж тухайн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлтэд хүрсэн байна. Үүний дараа 2023 онд 17,487 болж буурч, 2024 онд 6,222 хүртэл эрс багассан байна. 2025 онд 7,023 болж өмнөх оноос бага зэрэг өссөн боловч өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй бага түвшинд байна.


Хүснэгт 6. 2020-2025 оны эрхээ хасуулсан жолоочийн мэдээлэл



Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Баривчлах шийтгэл оногдуулсан хүний тоон үзүүлэлтийг 2020–2025 оны хооронд авч үзвэл мөн адил хэлбэлзэлтэй байна. Тухайлбал, 2020 онд 6,511 хүн баривчлагдсан бол 2021 онд 1,619 болж эрс буурсан байна. Харин 2022 онд 3,127 болж нэмэгдэж, 2023 онд 2,409, 2024 онд 2,374 болж бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. 2025 онд 2,750 болж өссөн байна.

Хүснэгт 7. 2020-2025 оны баривчлагдсан жолоочдын мэдээлэл



Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

2023 онд бүртгэгдсэн нийт зөрчлөөс авч үзвэл тодорхой төрлийн зөрчлүүд өндөр давтамжтай гарсан байна. Тухайлбал, эгнээ байр буруу эзлэх (14.7.27) зөрчил 475,214 удаа бүртгэгдэж хамгийн их давтамжтайд тооцогдож байна. Үүний дараа дугаарын хязгаарлалт зөрчих (14.7.57) 410,718 удаа, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцох (14.7.15) 153,379 удаа, зорчих хэсэг дээр түр зогсох (14.7.35.1) 153,203 удаа, түр болон удаан зогсох (14.7.37) 130,979 удаа, хурд хэтрүүлэх (14.7.31) 103,002 удаа, хамгаалах бүс хэрэглээгүй (14.7.20) 82,340 удаа, мөн танигдахгүй бохирдсон эсхүл буруу байрлуулсан улсын дугаартай тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцох (14.7.11.3) зөрчил 66,186 удаа тус тус бүртгэгдсэн байна. Иймд дээрх найман төрлийн зөрчил нь тухайн онд нийт зөрчлийн дийлэнх хувийг бүрдүүлж, давтамж өндөртэй байгааг харуулж байна.

Хүснэгт 8. 2023 онд хамгийн их давтамжтай зөрчлийн мэдээлэл

Торгуулийн дүн	Торгуулийн нэр	Зүйл анги	Нийт зөрчил
20,000	Эгнээ байр буруу эзлэх	14.7.27	475,214
20,000	Дугаарын хязгаарлалт	14.7.57	410,718

20,000	бүрэн бус тээврийн хэрэгсэл	14.7.15	153,379
20,000	Түр зогсох	14.7.35.1	153,203
10,000	Түр зогсох	14.7.37	130,979
50,000	Хурд хэтрүүлсэн	14.7.31	103,002
20,000	Хамгаалах бүс	14.7.20	82,340
10,000	танигдахгүй бохирдсон, эсхүл дугаарыг буруу байрлуулсан	14.7.11.3	66,186

Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2023)

2024 онд бүртгэгдсэн нийт зөрчлөөс авч үзвэл мөн адил тодорхой төрлийн зөрчлүүд өндөр давтамжтай гарсан байна. Тухайлбал, эгнээ байр буруу эзлэх (14.7.27) зөрчил 1,012,850 удаа бүртгэгдэж хамгийн их давтамжтайд тооцогдож байна. Үүний дараа зорчих хэсэг дээр түр зогсох (14.7.35.1) зөрчил 192,221 удаа, дугаарын хязгаарлалт зөрчих (14.7.57) 173,950 удаа, хамгаалах бүс хэрэглээгүй (14.7.20) 154,381 удаа, явган хүний гарц дээр зогсох (14.7.35.2) 122,121 удаа, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцох (14.7.15) 99,449 удаа, түр болон удаан зогсох (14.7.37) 83,557 удаа, мөн танигдахгүй бохирдсон эсхүл буруу байрлуулсан улсын дугаартай тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцох (14.7.11.3) зөрчил 42,481 удаа тус тус бүртгэгдсэн байна. Иймд дээрх найман төрлийн зөрчил нь тухайн онд нийт зөрчлийн дийлэнх хувийг бүрдүүлж, давтамж өндөртэй байгааг харуулж байна.

Хүснэгт 9. 2024 онд хамгийн их давтагдсан зөрчлийн мэдээлэл

Торгуулийн дүн	Торгуулийн нэр	Зүйл анги	Нийт зөрчил
20,000	Эгнээ байр буруу эзлэх	14.7.27	1,012,850
20,000	Түр зогсох	14.7.35.1	198,221
20,000	Дугаарын хязгаарлалт	14.7.57	173,950
20,000	Хамгаалах бүс	14.7.20	154,381
20,000	Явган хүний гарц дээр зогсох	14.7.35.2	122,121
20,000	бүрэн бус тээврийн хэрэгсэл	14.7.15	99,449
10,000	Түр зогсох	14.7.37	83,557
10,000	танигдахгүй бохирдсон, эсхүл дугаарыг буруу байрлуулсан	14.7.11.3	42,481

Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2024)

2025 онд бүртгэгдсэн нийт зөрчлөөс авч үзвэл тодорхой төрлийн зөрчлүүд өндөр давтамжтай хэвээр байна. Тухайлбал, эгнээ байр буруу эзлэх (14.7.27) зөрчил 1,291,984 удаа бүртгэгдэж хамгийн их давтамжтайд тооцогдож байна. Үүний дараа дугаарын хязгаарлалт зөрчих (14.7.57) 957,090 удаа, хамгаалах бүс хэрэглээгүй (14.7.20) 432,946 удаа, зорчих хэсэг дээр түр зогсох (14.7.35.1) 336,961 удаа, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцох (14.7.15) 275,065 удаа, явган хүний гарц дээр зогсох (14.7.35.2) 219,431 удаа, техникийн хяналтын үзлэгт оруулаагүй (14.7.10.2) 132,008 удаа, хурд хэтрүүлэх (14.7.31) 117,484 удаа тус тус бүртгэгдсэн байна. Иймд дээрх найман төрлийн зөрчил нь 2025 онд нийт зөрчлийн дийлэнх хувийг бүрдүүлж, давтамж өндөртэй байгааг харуулж байна.

Хүснэгт 10. 2025 онд хамгийн их давтамжтай зөрчлийн мэдээлэл

Торгуулийн дүн	Торгуулийн нэр	Зүйл анги	Нийт зөрчил
20,000	Эгнээ байр буруу эзлэх	14.7.27	1,291,984
20,000	Дугаарын хязгаарлалт	14.7.57	957,090
20,000	Хамгаалах бүс	14.7.20	432,946
20,000	Түр зогсох	14.7.35.1	336,961
20,000	бүрэн бус тээврийн хэрэгсэл	14.7.15	275,065
20,000	Явган хүний гарц дээр зогсох	14.7.35.2	219,431
50,000	Техникийн үзлэг	14.7.10.2	132,008
50,000	Хурд хэтрүүлсэн	14.7.31	117,484


Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2025)

Дээр дурдсан зөрчлүүдэд оногдуулж буй торгуулийн үнийн дүнг авч үзвэл харьцангуй бага түвшинд тогтоогдсон байна. Тухайлбал, түр болон удаан зогсох (14.7.37), танигдахгүй бохирдсон эсхүл буруу байрлуулсан улсын дугаартай холбоотой зөрчил (14.7.11.3)-д тус бүр 10 нэгж буюу 10,000 төгрөгийн торгууль ногдуулж байна. Харин эгнээ байр буруу эзлэх (14.7.27), дугаарын хязгаарлалт зөрчих (14.7.57), хамгаалах бүс хэрэглээгүй (14.7.20), зорчих хэсэг дээр түр зогсох (14.7.35.1), бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцох (14.7.15), явган хүний гарц дээр зогсох (14.7.35.2) зэрэг зөрчлүүдэд 20 нэгж буюу 20,000 төгрөгийн торгууль оногдуулж байна. Мөн техникийн хяналтын үзлэгт оруулаагүй (14.7.10.2), хурд хэтрүүлэх (14.7.31) зөрчлүүдэд 50 нэгж буюу 50,000 төгрөгийн торгууль ногдуулж байгаа нь замын хөдөлгөөний түгээмэл зөрчлүүдэд оногдуулж буй торгуулийн хэмжээ нь 10,000–50,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж байгааг харуулж байна.

2.1.3.2 Зам тээврийн ослын статистик болон ослын шалтгааны мэдээлэл

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.6 дугаар зүйл ангид “зам тээврийн осол” гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг хэлнэ гэж заасан байдаг. (Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль) 2020–2025 оны хооронд зам тээврийн ослын тоо тогтмол өсөх хандлагатай байсан нь ажиглагдаж байна. Тодруулбал, 2020 онд 18,513 осол бүртгэгдсэн бол 2021 онд 19,218 болж өссөн, 2022 онд 20,322, 2023 онд 21,053 болж нэмэгдсэн байна. Харин 2024 онд огцом өсөлт ажиглагдаж 26,056 осолд хүрсэн нь өмнөх жилүүдтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт болсон байна. 2025 онд 24,574 болж бага зэрэг буурсан ч өмнөх жилүүдийн түвшнээс өндөр хэвээр байна. (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Хүснэгт 11. 2020-2025 онд гарсан зам тээврийн ослын мэдээлэл



Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

Доорх судалгаанд ашигласан 2023–2025 оны зам тээврийн ослын шалтгааны статистик мэдээллээс харахад ослын дийлэнх хувь нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан байна. Тухайлбал, анхаарал болгоомжгүй байдал, уулзвар нэвтрэх журам зөрчих, хажуу хоорондын зай баримтлаагүй, эгнээ байр буруу эзэлсэн, ухрах үйлдэл буруу хийх зэрэг нь жил бүр өндөр давтамжтай бүртгэгдэж байгаа нь жолооч нар Замын хөдөлгөөний дүрэм зөрчснөөс болж зам тээврийн осол гарсныг илтгэж байна.

Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлэх зэрэг ноцтой зөрчлүүд тогтмол өсөх буюу өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь ослын эрсдэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. Ялангуяа хажуу хоорондын зай баримтлаагүй (2023 онд 8008, 2024 онд 9507, 2025 онд 7132), анхаарал болгоомжгүй (2023 онд 3040, 2024 онд 4244, 2025 онд 2341) зэрэг

зөрчлүүд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа нь жолоочийн сахилга бат, хариуцлага хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 12. 2023-2025 онд жолоочоос шалтгаасан буруутай үйлдлийн төрлүүд

№	Жолоочоос шалтгаалсан буруутай үйлдлийн төрлүүд	2023	2024	2025
1	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	547	1162	1560
2	Эм бэлдмэл, сэтгэцэд нөлөөлөх зүйл хэрэглэсэн	0	1	0
3	Хурд хэтрүүлсэн	683	932	812
4	Бүрэн бус тээврийн хэрэгслээр жолоодсон	26	45	22
5	Анхаарал болгоомжгүй	3040	4244	2341
6	Зогсоох арга хэмжээ аваагүй	529	756	517
7	Гэрэл дохио зөрчсөн	107	169	361
8	Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн	3831	2901	2554
9	Эргэх үйлдэл буруу хийсэн	67	397	191
10	Хажуу хоорондын зай тохируулаагүй	8008	9507	7132
11	Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн	46	91	71
12	Эсрэг урсгалд орсон	86	92	117
13	Эгнээ байр буруу эзэлсэн	1622	2411	1728
14	Ухрах үйлдэл буруу хийсэн	1652	2024	1509
15	Явган хүний гарцтай замаар зам хөндлөн гарч яваа явган зорчигчийн өнгөрүүлээгүй	110	264	201
16	Хэт ядарсан буюу нойрмоглосон	14	32	14
17	Гэрэл шилжүүлээгүй	1	0	2
18	Зогсолт, зогсоолын журам зөрчсөн	89	38	44
19	Чирэх үйлдэл буруу хийсэн	5	4	8
20	Хүн тээвэрлэх журам зөрчсөн	30	40	23
21	Ачаа тээвэрлэх журам зөрчсөн	3	11	14

22	Байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас үүссэн	0	0	2
	Техник хэрэгслийн засварыг шаардлагын түвшинд хийгээгүй	4	3	5
23	Хэргийн газраас зугтсан	51	184	69
	Нийт жолоочийн буруутай үйлдэл	20551	25308	19297

Эх сурвалж: (Тээврийн цагдаагийн алба, 2020-2025)

2.2 БНСУ-ын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн хариуцлага

БНСУ-ын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн хариуцлагын тогтолцоо нь бусад улс орнуудтай харьцуулахад илүү системтэй, шаталсан, олон талт байдлаар хэрэгждэг онцлогтой байна. Тус улсын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг зөвхөн хууль зүйн хариуцлагаар хязгаарлахгүйгээр, харин бодлого, хэрэгжилт, хяналт, мэдээлэл, боловсрол зэрэг олон хүчин зүйлийг нэгтгэсэн цогц системийн хүрээнд авч үздэг. Өөрөөр хэлбэл, хууль зүйн хариуцлага нь зөвхөн зөрчил гарсны дараа хэрэгжих арга хэмжээ биш, харин зөрчлийг урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний соёлыг төлөвшүүлэх бодлогын нэг хэсэг болж хөгжсөн байна. (Ph.D, 2002)

БНСУ-ын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага нь нэлээд өргөн хүрээтэй бөгөөд зөрчлийн шинж чанар, хор уршгийн хэмжээнээс хамааран ялгамжтайгаар оногдуулдаг. Тухайлбал, хөнгөн зөрчилд мөнгөн торгууль ногдуулах бол ноцтой зөрчилд баривчлах, цаашлаад эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүртэл арга хэмжээ авах боломжтой байдаг. Мөн тодорхой нөхцөлд зөвхөн жолооч бус, тухайн зөрчилд оролцсон байгууллага, ажил олгогчид хүртэл хариуцлага хүлээлгэх зохицуулалттай нь хариуцлагын хамрах хүрээг өргөжүүлсэн, илүү үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж байна. Энэ нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг хувь хүний сахилга баттай холбохоос гадна байгууллагын хариуцлагатай уялдуулж байгаагаараа онцлог юм. (Easy law, n.d.)

Гэвч БНСУ-ын туршлагын хамгийн чухал хэсэг нь зөвхөн хууль зүйн зохицуулалт бус, харин түүний хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцоо юм. Судалгааны үр дүнгээс харахад хурдны автомат хяналтын системийг (speed enforcement) нэвтрүүлснээр жолооч нарын хурд мэдэгдэхүйц буурч, зам тээврийн ослын улмаас нас барах тохиолдол 40–80 хувиар буурсан байна. Мөн судалгаанд оролцсон жолооч нарын 70 гаруй хувь нь жолоодлогын хэв маягаа өөрчилсөн нь тогтоогдсон нь хяналтын тогтолцоо нь хүний зан үйлд шууд нөлөөлдөг болохыг харуулж байна. Үүнээс үзэхэд шийтгэлийн хатуу байдал дангаараа хангалтгүй бөгөөд харин зөрчил гаргасан тохиолдолд зайлшгүй илэрч, хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдсэн үед л жолоочийн зан үйл бодитоор өөрчлөгддөг байна. (Ph.D, 2002)

Нөгөө талаас, БНСУ-д замын хөдөлгөөний зөрчил бүх жолоочид ижил хэмжээнд хамаарахгүй, харин тодорхой бага бүлэгт төвлөрдөг онцлог ажиглагддаг. Сүүлийн үеийн судалгаагаар нийт жолоочийн ойролцоогоор 1 хувь нь давтан зөрчил гаргагчид боловч тэд нийт зөрчлийн 10 гаруй хувийг бүрдүүлж байгаа нь тогтоогдсон. Энэ нь замын хөдөлгөөний зөрчлийг бууруулах бодлого нь бүх жолоочид ижил түвшинд чиглэхээс илүүтэйгээр эрсдэл өндөртэй бүлэгт чиглэсэн байх шаардлагатайг харуулж байна. Иймд БНСУ-ын хувьд давтан зөрчил гаргагчдад илүү хатуу, шаталсан, ялгавартай арга хэмжээ хэрэгжүүлэх нь бодит үр дүн авчирдаг гэж үздэг. (Oh-Eun, 2025)

БНСУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тогтолцоонд технологи, мэдээллийн систем онцгой байр суурь эзэлдэг. Тухайлбал, Korea Road Traffic Authority байгууллага нь зам тээврийн ослын мэдээллийг нэгтгэн боловсруулдаг Traffic Accident Analysis System (TAAS)-ийг ашигладаг бөгөөд энэ систем нь ослын шалтгаан, нөхцөл, байршил, давтамж, оролцогчдын онцлог зэрэг мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийх боломж олгодог. Ийнхүү мэдээлэлд суурилсан дүн шинжилгээ хийх нь бодлого боловсруулагчдад эрсдэлтэй бүс, давтамж өндөртэй зөрчлийг тодорхойлох, улмаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой төлөвлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, зөрчил гарсны дараа шийтгэх бус, харин зөрчил гарахаас өмнө урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч байгаа нь тус улсын бодлогын давуу тал юм. (Easy law, n.d.)

Үүнээс гадна жолоочийн боловсрол, сургалт, олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх бодлого нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй. БНСУ-д жолооч бэлтгэх сургалт, шалгалт, давтан сургалт, аюулгүй байдлын талаарх сурталчилгааг тогтмол зохион байгуулдаг бөгөөд энэ нь жолоочийн зан үйлийг урт хугацаанд өөрчлөхөд чиглэдэг. Энэ нь замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг зөвхөн хяналт, шийтгэлээр бус, хүний ухамсар, хандлагаар дамжуулан сайжруулах боломжтойг харуулж байна. (Easy law, n.d.)

Дээрх бүх мэдээллийг нэгтгэн дүгнэж үзвэл БНСУ-ын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн хариуцлага нь зөвхөн шийтгэлийн төрөл, хэмжээгээр хязгаарлагдахгүй, харин түүний хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцоо, илрүүлэлтийн баталгаатай байдал, технологийн дэмжлэг, мэдээлэлд суурилсан бодлого, урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй уялдсан цогц системд тулгуурлаж байна. Энэ нь замын хөдөлгөөний зөрчлийг бууруулахад зөвхөн торгууль нэмэх, шийтгэл чангаруулах замаар үр дүнд хүрэх боломж хязгаарлагдмал бөгөөд харин хэрэгжилтийг сайжруулах, илрүүлэлтийн баталгааг нэмэгдүүлэх, эрсдэлтэй бүлэгт чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй болохыг харуулж байна. (Ph.D, 2002)

Иймд энэхүү туршлагыг Монгол Улсын нөхцөл байдалтай харьцуулан авч үзвэл манай улсад хэрэгжиж буй торгууль, жолоодох эрх хасах, баривчлах зэрэг хууль зүйн хариуцлагын арга хэмжээг үр нөлөөтэй болгохын тулд тэдгээрийн хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцоо, технологийн дэмжлэг, мэдээллийн сангийн хөгжлийг сайжруулах шаардлагатай байна. Мөн давтан зөрчил гаргагчдад чиглэсэн бодлого, жолоочийн боловсрол, ухамсрыг дээшлүүлэх арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэх нь замын хөдөлгөөний зөрчлийг бууруулахад илүү бодит үр дүн авчирна гэж дүгнэж байна.

2.3 АНУ-ын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн хариуцлага

АНУ-д замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн хариуцлага нь нэгдсэн нэг хуулиар бус, холбооны улсын тогтолцоонд тулгуурлан муж бүрийн хууль тогтоомж, захиргааны байгууллага, шүүхийн журмаар зохицуулагддаг онцлогтой. Иймээс ижил төрлийн зөрчил өөр өөр муж улсад харилцан адилгүй хэмжээний торгууль, оноо, эрх зүйн үр дагавартай байх боломжтой бөгөөд энэ нь АНУ-ын эрх зүйн зохицуулалтын ялгарах онцлог юм. Судалгаанаас харахад зарим муж улсад замын хөдөлгөөний зөрчилд илүү хатуу бодлого хэрэгжүүлдэг бол заримд нь харьцангуй зөөлөн зохицуулалттай байдаг бөгөөд жишээлбэл Орегон, Аляска зэрэг мужууд хатуу зохицуулалттай, харин Техас зэрэг мужууд харьцангуй зөөлөнд тооцогддог байна. (Riordan, 2023)

АНУ-ын замын хөдөлгөөний зөрчлийн эрх зүйн зохицуулалт нь зөвхөн мөнгөн торгуулиар хязгаарлагдахгүй, харин торгууль, онооны систем, жолоодох эрхийн хязгаарлалт, шүүхийн оролцоо, эрүүгийн хариуцлага, мөн даатгалын эдийн засгийн үр дагавар зэрэг олон талт арга хэмжээг уялдуулсан цогц тогтолцоо юм. Энэ нь жолоочийн зан үйлийг зөвхөн нэг удаагийн шийтгэлээр бус, урт хугацаанд хянах, давтан зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилготой хэрэгждэг. (OPTTRAFFIC, 2024), (Motuzov, n.d.)

АНУ-д замын хөдөлгөөний зөрчлийг ерөнхийд нь хөнгөн (infractions), дунд зэргийн буюу захиргааны шинжтэй (misdemeanor), мөн эрүүгийн шинжтэй ноцтой зөрчил (felony) гэж ангилдаг. Хөнгөн зөрчилд хурд хэтрүүлэх, гэрлэн дохио зөрчих, зогсох тэмдэг зөрчих, хамгаалах бүс хэрэглэхгүй байх зэрэг үйлдэл багтдаг бол ноцтой зөрчилд согтуугаар жолоодох (DUI/DWI), болгоомжгүй жолоодох, ослын газраас зугтах, эрх нь түдгэлзсэн үед жолоодох зэрэг ордог. Ийм ноцтой зөрчил нь зөвхөн торгууль бус, эрүүгийн хариуцлага, хорих ял, шүүхийн хяналт зэрэг илүү хатуу үр дагаварт хүргэх боломжтой. (OPTTRAFFIC, 2024)

Мөнгөн торгуулийн хэмжээ нь зөрчлийн төрөл, ноцтой байдал, давтамжаас хамааран өргөн хүрээнд хэлбэлздэг. Судлагдсан эх сурвалжуудаас үзэхэд хурд хэтрүүлэхэд ойролцоогоор 50–500 ам.доллар, согтуугаар жолоодох үед 500–2000 ам.доллар ба түүнээс дээш, болгоомжгүй жолоодох үед 200–1000 ам.доллар хүртэл, даатгалгүй жолоодох үед 100–1500 ам.доллар хүртэл торгууль ногдуулах боломжтой байна. (OPTTRAFFIC, 2024) Түүнчлэн улаан гэрлээр нэвтрэх, зогсох тэмдэг зөрчих, гар утас ашиглах зэрэг нийтлэг зөрчлүүдэд 50–400 ам.долларын торгууль ногдуулдаг байна. (Motuzov, n.d.)

Муж улсын түвшний бодит жишээг авч үзвэл Missouri мужийн Clay County Circuit Court-ийн мэдээллээр хурд хэтрүүлэхийг шаталсан байдлаар нарийвчлан тогтоож, 1–5 mph хэтрүүлсэн тохиолдолд 120 ам.доллар, 6–10 mph бол 134 ам.доллар, 11–15 mph бол 144 ам.доллар, 16–19 mph бол 174 ам.доллар, 20–25 mph бол 229 ам.долларын торгууль ногдуулдаг байна. Харин 25 mph-аас дээш хэтрүүлсэн, осолтой холбоотой, эсвэл хэргийн

газрыг орхисон тохиолдолд торгуулиар шийдвэрлэхгүй, заавал шүүхэд шилжүүлдэг. Мөн сургуулийн бүс, барилгын бүсэд зөрчил гаргавал нэмэлт төлбөр ногдуулдаг нь илүү аюултай нөхцөлд хатуу зохицуулалт хэрэгжүүлж байгааг харуулж байна. (7th Judicial Circuit Court, Clay county, Missouri, 2024)

АНУ-ын эрх зүйн зохицуулалтын чухал бүрэлдэхүүн нь онооны систем юм. Зөрчил бүрт жолоочид тодорхой хэмжээний оноо нэмэгддэг бөгөөд хурд хэтрүүлэхэд 2–4 оноо, улаан гэрлээр нэвтрэхэд 2–3 оноо, ноцтой зөрчилд 4–6 ба түүнээс дээш оноо ногдуулдаг байна. Зарим эх сурвалжид хурдны хэтрэлтийн хэмжээнээс хамаарч оноо шатлалтай нэмэгддэг гэж дурдсан байна (optraffic.com; americanbutler.ru). Оноо тодорхой хэмжээнд хүрэхэд жолоодох эрхийг түр түдгэлзүүлэх, улмаар бүрэн хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах боломжтой байдаг. (OPTTRAFFIC, 2024)

Захиргааны болон эрүүгийн хариуцлагын зааг АНУ-д тодорхой ялгаатай хэрэгждэг. Захиргааны хариуцлагад торгууль, оноо, эрх түдгэлзүүлэх зэрэг арга хэмжээ багтдаг бол эрүүгийн хариуцлагад DUI, reckless driving зэрэг ноцтой зөрчилд хорих ял, шүүхийн хяналт, заавал сургалт зэрэг арга хэмжээ авдаг. Зарим тохиолдолд анхны зөрчилд хүртэл хорих ял оногдуулах боломжтой бөгөөд давтан зөрчилд илүү хатуу шийтгэл ногдуулдаг. (OPTTRAFFIC, 2024)

АНУ-ын замын хөдөлгөөний зөрчлийн эрх зүйн зохицуулалтын нэг онцгой шинж нь даатгалын системтэй шууд уялддаг явдал юм. Жолоочийн зөрчлийн түүх нь даатгалын байгууллагын эрсдэлийн үнэлгээний үндсэн үзүүлэлт болдог бөгөөд зөрчил гаргасан жолоочийг өндөр эрсдэлтэй гэж үзэн даатгалын хураамжийг нэмэгдүүлдэг байна. (insurance, 2025) Судалгаагаар энгийн хурд хэтрүүлэх зөрчил ч даатгалын төлбөрийг 20–30 хувиар өсгөх боломжтой бөгөөд энэ өсөлт 3–5 жилийн хугацаанд үргэлжилдэг байна. Мөн нэг зөрчил нь нийтдээ хэдэн зуун, зарим тохиолдолд хэдэн мянган ам.долларын нэмэлт зардал үүсгэх боломжтой бөгөөд согтуугаар жолоодох зэрэг ноцтой зөрчилд даатгалын гэрээ цуцлагдах хүртэл эрсдэлтэй байдаг. (Bruner, 2025)

Түүнчлэн замын хөдөлгөөний торгуулийг үл тоомсорлох нь илүү ноцтой эрх зүйн үр дагаварт хүргэдэг. Торгуулийг хугацаанд нь төлөхгүй бол нэмэлт төлбөр нэмэгдэхээс гадна шүүхэд шилжих, улмаар баривчлах захирамж гаргах, жолоодох эрхийг түдгэлзүүлэх зэрэг арга хэмжээ авах боломжтой байдаг. Иймд энгийн захиргааны зөрчил нь үл тоомсорлосноор эрүүгийн шинжтэй асуудал болон хувирах эрсдэлтэй байдаг. (Devendorf, 2025)

Ийнхүү АНУ-ын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн хариуцлага нь торгууль, оноо, эрх хасалт, шүүхийн оролцоо, даатгалын эдийн засгийн нөлөөллийг уялдуулсан, олон давхаргат, урт хугацааны үр нөлөө бүхий цогц тогтолцоо бөгөөд жолоочийн зан үйлийг хянах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилготойгоор хэрэгжиж байна.

Бүлгийн дүгнэлт:

Монгол Улс, БНСУ, АНУ-ын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын тогтолцоог харьцуулан судалсны үндсэн дээр дүгнэж үзэхэд эдгээр улсын эрх зүйн зохицуулалт нь бүтэц, хэлбэрийн хувьд харилцан адилгүй боловч нийтлэг зорилго нь жолоочийн зан үйлд нөлөөлөх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах явдал байна. Монгол Улсын хувьд хууль эрх зүйн зохицуулалт (торгууль, жолоодох эрх хасах, баривчлах) хангалттай бүрдсэн боловч түүний бодит хэрэгжилт, үр нөлөө сул, ялангуяа зөрчлийн тоо буурахгүй өсөх хандлагатай байгаа нь эрх зүйн хариуцлагын нөлөөлөл хангалтгүй байгааг илтгэж байна. Үүнд торгуулийн хэмжээ харьцангуй бага, шийтгэлийн зайлшгүй хэрэгжилт сул, жолоочийн хууль сахих хандлага хангалтгүй зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлж байна.

Харин БНСУ-ын туршлагаас харахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого нь зөвхөн шийтгэлд суурилах бус, харин хяналт, технологи, мэдээллийн нэгдсэн сан, боловсролын бодлоготой уялдсан цогц тогтолцоонд тулгуурладаг нь илүү үр дүнтэй болох нь харагдаж байна. Ялангуяа автомат хяналтын систем, илрүүлэлтийн өндөр баталгаатай байдал нь жолоочийн зан үйлд шууд нөлөөлж, зөрчил, ослыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн давтан зөрчил гаргагчдад чиглэсэн ялгамжтай бодлого хэрэгжүүлдэг нь үр нөлөөг нэмэгдүүлдэг онцлогтой байна.

АНУ-ын хувьд замын хөдөлгөөний зөрчилд хүлээлгэх хариуцлага нь торгууль, онооны систем, жолоодох эрхийн хязгаарлалт, шүүхийн хяналт, даатгалын эдийн засгийн үр дагавар зэрэг олон талт механизмыг хослуулсан, урт хугацааны нөлөөлөл бүхий цогц тогтолцоо байна. Ялангуяа даатгалын системтэй уялдсан эдийн засгийн дарамт нь жолоочийн зан үйлд хүчтэй нөлөөлж, давтан зөрчил гаргахаас сэргийлэх үр дүнтэй хэрэгсэл болж байна.

Иймээс харьцуулсан судалгааны үр дүнгээс дүгнэхэд Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахын тулд зөвхөн торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх бус, харин:

- шийтгэлийн зайлшгүй хэрэгжилтийг хангах,
- хяналт, илрүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох,
- технологид суурилсан хяналтыг өргөжүүлэх,
- мэдээллийн нэгдсэн сан, дүн шинжилгээнд тулгуурласан бодлого хэрэгжүүлэх,
- давтан зөрчил гаргагчдад чиглэсэн ялгамжтай арга хэмжээ авах,
- жолоочийн боловсрол, ухамсрыг дээшлүүлэх

зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн торгуулийн хэмжээг өрхийн сарын дундаж орлоготой харьцуулан үзэхэд Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд оногдуулж буй хамгийн бага торгууль нь иргэдийн орлогын түвшинтэй харьцуулахад харьцангуй бага байна. Тухайлбал, Монгол Улсын өрхийн сарын дундаж орлого 2,803,740 төгрөг байхад хамгийн бага торгууль 10,000 төгрөг байгаа нь нийт орлогын ердөө 0.36 хувийг эзэлж байна. (Үндэсний статистикийн хороо, огноо байхгүй) Харин АНУ-д өрхийн сарын

дундаж орлого 6,977.5 доллар, хамгийн бага торгууль 50 доллар байгаа нь 0.72 хувь, БНСУ-д өрхийн сарын дундаж орлого 5,420,000 вон, хамгийн бага торгууль 40,000 вон байгаа нь 0.74 хувийг тус тус эзэлж байна. (Melissa Kollar, 2025), (KOREA PRO, 2026) Үүнээс харахад Монгол Улсын торгуулийн доод хэмжээ нь АНУ, БНСУ-тай харьцуулахад өрхийн орлогод эзлэх хувиараа бараг хоёр дахин бага байгаа бөгөөд энэ нь торгуулийн шийтгэлийн санхүүгийн нөлөөлөл сул, жолоочийн зан үйлд бодитойгоор нөлөөлөх чадвар хангалтгүй байж болзошгүйг харуулж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөө нь зөвхөн шийтгэлийн хатуу байдалд бус, харин түүний хэрэгжилтийн бодит байдал, хяналтын үр ашиг, жолоочийн зан үйлд үзүүлэх нөлөөлөлтэй шууд хамааралтай бөгөөд Монгол Улсад энэ чиглэлээр бодлогын шинэчлэл, цогц хандлага нэн шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1 Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх эрх зүйн хариуцлагын зохицуулалт, түүний үр нөлөөг тодорхойлохын тулд онол, эрх зүйн зохицуулалт, практик хэрэглээ, олон нийтийн хандлагыг хамтатган авч үзэх арга зүйн хандлагыг ашиглав. Судалгааны хүрээнд системчлэн судлах арга, харьцуулсан судалгааны арга, асуулгын судалгааны аргыг түлхүү хэрэглэсэн болно. Захиргааны эрх зүйн онолын үндэс, Зөрчлийн тухай хууль болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зохицуулалтыг харилцан уялдаа холбоотойгоор судалсан. Ингэхдээ замын хөдөлгөөний зөрчил, түүнд ногдуулах торгууль, эрх хасах, баривчлах зэрэг хариуцлагын хэлбэрүүд, тэдгээрийн хэрэгжилт болон үр нөлөөг нэг бүхэл систем гэж үзэн дүн шинжилгээ хийсэн. Энэхүү арга нь эрх зүйн зохицуулалтын бүтэц, хэрэгжилт болон үр нөлөөний хоорондын уялдаа холбоог тодорхойлох боломжийг бүрдүүлсэн болно.

Салбарын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох: Харьцуулсан судалгааны аргыг ашиглаж, АНУ, БНСУ болон Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн хариуцлагын зохицуулалтыг харьцуулан судалсан. Энэхүү харьцуулалт нь тухайн улсын эрх зүйн орчин, зөрчилд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэрэгжүүлэх механизм, үр нөлөөний онцлогийг харьцуулан дүгнэхэд чиглэсэн. АНУ-ын хувьд мужийн онцлогоос шалтгаалсан зохицуулалтын ялгаа, торгууль болон жолоодох эрх хязгаарлах арга хэмжээний хэрэглээг авч үзсэн бол БНСУ-ын хувьд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хатуу хяналт, цахимжсан хариуцлагын тогтолцооны онцлогийг анхааран судалсан. Харин Монгол Улсын хувьд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд ногдуулах торгууль, эрх хасах, баривчлах зэрэг хууль эрх зүйн хариуцлагын хэлбэр, тэдгээрийн хэрэгжилтийн бодит нөхцөл байдлыг авч үзсэн. Ийнхүү харьцуулсан судалгаагаар гадаад улсын туршлага болон дотоодын эрх зүйн зохицуулалтын давуу болон сул талыг тодорхойлохыг зорьсон.

Чанарын судалгааны арга: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн шалтгаан, нөхцөл болон эрх зүйн хариуцлагын үр нөлөөг тодорхойлох зорилгоор асуулгын судалгааны аргыг ашигласан. Нэгдүгээрт, жолооч нараас авсан асуулгын судалгаагаар замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргах шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, үүнд жолоочийн мэдлэг, сахилга хариуцлага, замын нөхцөл болон хяналтын түвшин зэрэг хүчин зүйлсийг авч үзсэн. Хоёрдугаарт, нөлөө бүхий алба хаагчдаас авсан асуулгын судалгаагаар зөрчилд хүлээлгэх торгууль, эрх хасах, баривчлах зэрэг хариуцлагын арга хэмжээ нь зөрчил бууруулахад хэрхэн нөлөөлж буй, хэрэгжилтийн бодит байдлыг үнэлсэн. Ийнхүү хоёр талын оролцогчдоос мэдээлэл цуглуулснаар зөрчлийн шалтгаан, нөхцөл болон эрх зүйн хариуцлагын үр нөлөөг бодитойгоор тодорхойлох боломж бүрдсэн.

БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1 Судалгааны үндэслэл

- * Судалгааны онолын суурийг бодит байдалтай холбох
- * Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хариуцлага нь үр нөлөөтэй байгаа эсэхд дүн шинжилгээ хийх
- * Үр дүнд тулгуурлан санал зөвлөмж боловсруулах боломжийг бүрдүүлэх

4.2 Судалгааны зорилго

Жолооч нараас асуумжийн аргаар мэдээлэл авч, замын хөдөлгөөний дүрэм зөрчихөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, мөн зөрчилд оногдуулж буй хууль зүйн хариуцлагын үр нөлөө нь жолоочийн зан үйлд хэрхэн нөлөөлж байгааг судлан тогтоох мөн замын хөдөлгөөн зохицуулж буй хамгийн их зөрчил гардаг дүүргүүдийн замын цагдаа нараас зөрчилд хүлээлгэх торгууль, эрх хасах, баривчлах зэрэг хариуцлагын арга хэмжээ нь зөрчил бууруулахад хэрхэн нөлөөлж буй, хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлох зорилготой ярилцлагын хэлбэрээр асуулгыг авсан. Ингэснээр замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад чиглэсэн хууль зүйн зохицуулалтын үр нөлөөг бодит байдалд үнэлэх, цаашид боловсронгуй болгох үндэслэлийг бүрдүүлэх ач холбогдолтой.

4.3 Судалгааны арга зүй

Судалгаанд **чанарын судалгааны аргыг** ашигласан. Үүнд:

- **Жолооч** нараас 21 сонголттой 3 нээлттэй хариулттай 24 асуулт бүхий асуулгыг боловсруулж нийт 384 хүнээс асуух асуулгын судалгаа
- **Замын цагдаагийн алба хаагчдаас** 14 асуулт бүхий ярилцлагын удирдамж боловсруулж ярилцлагын судалгаа

4.4 Судалгааны хязгаарлалт


- * Судалгааны хамрах хүрээ нь зөвхөн Монгол улсын жишээн дээр хязгаарлагдсан ба замын хөдөлгөөнд оролцогч талууд буюу жолооч болон замын цагдаагийн алба хаагчдыг хамарсан.
- * Судалгаанд өгсөн зарим хариулт нь хувь хүний субъектив сэтгэл хөдлөл, тухайн өдрийн нөхцөл байдалд автсан байх магадлалтай.
- * Судалгаа нь 2026 оны тодорхой хугацаанд хийгдсэн тул тухайн үеийн нөхцөл байдалд хамаарсан дүгнэлт гарсан. Цаг хугацааны өөрчлөлттэй уялдан үр дүн өөрчлөгдөх боломжтой.

4.5 Асуулгын болон ярилцлагын судалгааны үр дүн.


Асуулгын судалгаа: Судлаач нь 21 сонголттой 3 нээлттэй хариулттай 24 асуулт бүхий асуулгыг боловсруулж нийт 384 хүнээс асуух асуулгын судалгаа авсан болно.

4.5.1 Асуулгын судалгаа


Зураг 4 Асуулт 1. Судалгаанд оролцогчдийн нас




Зураг 5 Асуулт 2. Судалгаанд оролцогчдийн хүйс




Зураг 6 Асуулт 3. Судалгаанд оролцогчдийн боловсрол




Зураг 7 Асуулт 4. Судалгаанд оролцогчдын амьдардаг дүүрэг




Зураг 8 Асуулт 5. Та жолооч болоод хэдэн жил болж байгаа вэ?




Зураг 9 Асуулт 6. Та тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд ямар давтамжтай оролцдог вэ?




Зураг 10 Асуулт 7. Та ихэвчлэн ямар зорилгоор тээврийн хэрэгсэл жолооддог вэ?




Зураг 11 Асуулт 8. Та өөрийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг үнэлнэ үү.




Зураг 12 Асуулт 9. Та замын хөдөлгөөн зөрчиж байсан эсэх.




Зураг 13 Асуулт 10. Хэрэв тийм бол ямар дүрэм зөрчиж байсан бэ?




Зураг 14 Асуулт 11. Таны хувьд жолооч нарыг замын хөдөлгөөний дүрэм зөрчихөд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийг сонгоно уу?




Зураг 15 Асуулт 12. Та ямар хүчин зүйлсийн улмаас замын хөдөлгөөний дүрмийг зөрчдөг вэ?




Зураг 16 Асуулт 13. Та замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагын талаар хэр сайн мэдэх вэ? (1-5 оноо: 1=мэдэхгүй, 5= маш сайн мэднэ)




Зураг 17 Асуулт 14. Таны бодлоор одоо мөрдөгдөж буй торгуулах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1-5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=Маш үр нөлөөтэй)




Зураг 18 Асуулт 15. Таны бодлоор одоо мөрдөж буй жолоодох эрх хасах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1-5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=маш үр нөлөөтэй)




Зураг 19 Асуулт 16. Таны бодлоор одоо мөрдөгдөж буй баривчлах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1–5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=маш үр нөлөөтэй)



Зураг 20 Асуулт 17. Дараах зөрчлийн шийдвэрлэлтүүдээс аль нь жолоочид дахин зөрчил үйлдэхгүй байхад нөлөөлдөг гэж та үзэж байна вэ?




Зураг 21 Асуулт 18. Таны бодлоор замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад аль арга хэмжээ хамгийн үр дүнтэй вэ?




Асуулт 19. Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулах талаар таны санал

Асуулт 20. Ухаалаг камерын системийн талаарх таны бодол юу вэ? (Ai)


Зураг 22 Асуулт 21. Ухаалаг камерын системийн зөрчил илрүүлэлт болон торгууль ногдуулдаг журмын талаар мэдээлэл хангалттай авч чадаж байна уу?



Зураг 23 Асуулт 22. Ухаалаг камер, AI хяналттай үед та дүрэм зөрчихөөс илүү болгоомжилдог уу?



Зураг 24 Асуулт 23. Аль нь илүү үр дүнтэй гэж та үзэж байна вэ?



Асуулт 24. Яагаад тэгж үзэж байна вэ?

4.5.2 Асуулгын судалгааны дүгнэлт:

Жолооч нараас авсан асуулгын судалгаанд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн эсэхийг тодруулахад оролцогчдын дийлэнх нь “тийм” гэж хариулсан нь замын хөдөлгөөний зөрчил өргөн тархсан байгааг харуулж байна.

Зөрчлийн төрлийг тодруулахад хамгийн түгээмэл нь дугаарын хязгаарлалт зөрчих, нийтийн тээврийн эгнээгээр зорчих, уулзвар нэвтрэх журам болон замын тэмдэг, тэмдэглэгээ зөрчих зэрэг зөрчлүүд байсан бөгөөд эдгээр нь ихэвчлэн хотын түгжрэл, замын ачаалалтай холбоотойгоор үүсэж байгааг харуулж байна.

Жолооч нарыг дүрэм зөрчихөд нөлөөлөх хүчин зүйлийг тодруулахад “замын ачаалал, түгжрэл” хамгийн олон давтагдсан хариулт байсан бөгөөд үүний дараа “яарч сандрах”, “хувийн хариуцлага сул”, “дүрмийн мэдлэг дутмаг”, “бусад жолоочийг дагах” зэрэг хүчин зүйлс зонхилж байна. Энэ нь замын хөдөлгөөний зөрчил нь зөвхөн хувь хүний буруутай үйлдэл бус, гадаад орчны нөлөө их байгааг илэрхийлж байна.

Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагын үр нөлөөг үнэлэхэд торгуулийн арга хэмжээ нь дунд түвшний үнэлгээ авсан бол жолоодох эрх хасах болон баривчлах арга хэмжээг илүү үр нөлөөтэй гэж үзсэн хандлага ажиглагдсан. Ялангуяа олон оролцогч торгуулийн хэмжээ нь зөрчил үйлдэхээс сэргийлэх хангалттай хөшүүрэг болж чаддаггүй гэж дурдсан нь анхаарал татаж байна.

Зөрчлийг бууруулах арга хэмжээний тухай асуултад оролцогчид замын зохион байгуулалтыг сайжруулах, камер болон цахим хяналтыг нэмэгдүүлэх, торгуулийн хэмжээг өсгөх, жолоочийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг илүү үр дүнтэй гэж үзсэн байна. Энэ нь зөрчил бууруулахад зөвхөн нэг төрлийн арга хэмжээ бус, олон талт бодлого шаардлагатайг илтгэж байна.

Ухаалаг камер, хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын системийн талаар ихэнх оролцогч эерэг байр суурьтай байсан бөгөөд ийм хяналттай үед дүрэм зөрчихөөс илүү болгоомжилдог гэж хариулсан байна. Гэвч зарим оролцогч буруу торгууль илрүүлэх, нөхцөл байдлыг ялгах чадвар сул зэрэг сул талыг дурдсан бөгөөд зөвхөн автомат хяналтаас илүү “хосолсон хэлбэр” буюу камер болон цагдаагийн хяналтыг хамтад нь хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзсэн байна.

4.6 Ярилцлагын судалгаа

Судлаач нь 14 асуулт бүхий ярилцлагын удирдамж боловсруулж, хамгийн их замын хөдөлгөөний дүрэм зөрчигддөг дүүргүүдийг сонгож дүүрэг тус бүрээс замын цагдаагийн газрын тус тус 1 цагдаагийн алба хаагчаас ярилцлагын судалгаа авсан. (Ярилцагч нар нь овог нэр болон албан тушаалыг судалгааны ажилд дурдахгүй байхыг хүссэн тул нууцлав)

Ярилцагч 1:

1-р асуулт: Та хэдэн жил замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр ажиллаж байна вэ?

Хариулт: Тасралтгүй 4 жил ажиллаж байна

2-р асуулт: Өдөрт дунджаар хэдэн зөрчил илрүүлж, шийдвэрлэдэг вэ?

Хариулт: Өдөрт дунджаар 30 замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочид арга хэмжээ авдаг. Дийлэнх зөрчил нь

3-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын арга хэмжээ (торгууль, эрх хасах, баривчлах) жолооч нарын давтан зөрчил үйлдэхээс хэр үр дүнтэй сэргийлж байгаа гэж дүгнэж байна вэ? Яагаад?

Хариулт: ер нь бол хууль чангарсан. Баривчлах шийтгэл нь бол согтуугаар жолоо барьсан тохиолдолд үйлчилдэг. Баривчлах шийтгэл оногдуулаад, эрхээ хасуулсан үедээ дахин жолоодвол эрүүгийн тухай хуулийн тусгай ангийн 27.10.5 гээд Эрүүгийн хуулиар шийдвэрлэж байгаа. Энэ нь өөрөө 6 сараас 3 жил хорих ялтай, 2 сая 700 мянгаас 14 сая төгрөг хүртэлх торгуулийн ялтай, 3 сараас 3 жил хүртэлх зорчих эрх хязгаарлах гэсэн ялтай. Мэдээж хэрэг эрхийг нь хасахдаа хууль тайлбарлаж сануулж байгаа, одоо бол өмнөх шиг биш согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон бүх зөрчил шүүхээр ордог болсон. 7-30 хоног баривчлах эсхүл 400 нэгжээр торгох уу гэдгийг шүүх гаргана. Шүүх дээр очиход шүүгч болон прокурор ийм хэргийг давтан үйлдэхэд зөрчил биш гэмт хэрэг болсон шүү гэдгийг сануулж байгаа. Одоо хууль чангарсан тул давтан хэрэг харьцангуй бага байгаа, өмнө нь бол согтуу жолоодох дээрээ баривчлагдаад явдаг байсан.

4-р асуулт: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил болон оногдуулж буй торгуулийн хэмжээ нь танд хэр нийцтэй санагдаж байна вэ? Яагаад?

Хариулт: Бусад улс орнуудтай харьцуулахад манай улсын зөрчлийн торгуулийн хэмжээ маш бага байдаг. Зөрчлийн тухай хуулиар бүс зүүгээгүй, 1-р эгнээгээр зорчих, дугаарын хязгаарлалттай өдөр зорчих торгуульд иргэнд 20 мянган төгрөг ногдуулж байгаа. Тухайн иргэн сайн дураараа 14 хоногийн дотор торгуулиа төлөхөд 50 хувь хөнгөлөгдөөд 10 мянгыг тушааж байгаа. Тухайн торгууль нь хөнгөлөгдөөд хэтэрхий бага байгаа тул жолоочид дахин дахин дүрэм зөрчих нь их байна. Жишээ нь 1 иргэн гэрлэн дохио зөрчөөд 20 мянган төгрөгөөр торгуулхад тухайн торгууль нь хөнгөлөгдөөд 10 мянган төгрөг төлөхийг мэдэж байгаа тул дараагийн гэрлэн дохиог зөрчиж байгаа. Торгуулийн хэмжээ нь нийцэхгүй байгаа тул жолоочдын зөрчил гаргаж байгаа нь давтамжтай байдаг.

5-р асуулт: Хууль хэрэгжүүлэх явцад ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ?

Хариулт: Жишээ нь би гар утсаар ярьж замын хөдөлгөөнд оролцож байгаа жолоочийг зогсоож арга хэмжээ тооцох тухайгаа хэлэхэд би утсаар яриагүй гэж хэлж мэлздэг. Тэгээд арга хэмжээ тооцоход хэл амаар доромжлох бэрхшээл маш ихээр тулгардаг. Цагдаагийн алба хаагчидад хамгийн ихээр тулгардаг асуудал нь жолооч зөрчлөө сайн дураараа хүлээн зөвшөөрдөггүй, тухайн зөрчилд арга хэмжээ авахад алба хаагчийг хэл амаар доромжилдог.

6-р асуулт: Зөрчил гаргасан жолооч нар шийтгэлээс зайлсхийх оролдлого гаргадаг уу? Хэрхэн? **Дээрх хариулт нь энэ асуултанд бас хариулсан болно.**

7-р асуулт: Хяналт, шалгалтын тогтолцоо хангалттай түвшинд байна гэж үзэж байна уу?

Хариулт: Хяналт шалгалтын тогтолцоо хангалттай түвшинд байдаг. Байнгын хувиар томилгоо гаргаж, хяналт шалгалтыг яаж хийх талаар, алба хаагч нарт сэтгэл зүйн,

хүнтэй харьцах, зөрчил үйлдэгч ямар байдалтай байх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож байгаа зөрчлийг яаж зогсоох гэх мэтчилэн бүх төрлийн сургалтыг заадаг тул хангалттай байдаг.

8-р асуулт: Мөрдөгдөж буй торгуулийн систем нь оновчтой хэрэгжиж байгаа гэж үзэж байна уу? Хэрвээ үгүй бол таны бодлоор ямар шинэчлэлт болон зохицуулалт шаардлагатай вэ?

Хариулт: Хангалттай биш байгаа. 1-т хөнгөлөөд байгаа байдал нь тохиромжгүй байгаа. Энэ хөнгөлөөд байгаа байдал нь өөрөө хүмүүсийг дахин зөрчил гаргахад өөхшүүлж байгаа. Жишээ нь, халаасандаа 400 мянган төгрөгтэй явж байгаа хүнд 50 мянгаар торгуулах нь сонин биш. 50 мянгаар торгуулна гэдэг нь 5 удаа 20 мянган төгрөгөөр торгуулна гэсэн үг. Тэр хүнд өдөрт 5 удаа зөрчил гаргах эрх байгаад байна. Тэгэхээр, хөнгөлөөд байгаа байдлыг болиулаад, мөнгөн торгуулийн дүнг нэмээд өгөхөд хэн ч зүгээр нэг гэрлэн дохио зөрчөөд 70 мянган төгрөг төлөхийг хүсэхгүй. Ингээд ирвэл алба хаагч шалгаад байх шаардлага үүсэхгүй. 2-т би БНСУ-д амьдарч байсан. Хамгийн өндөр торгууль нь сургууль орчимд 20 км цагийн хурдаас дээш явахыг хориглодог, дээш явахад л шууд торгууль нь 100,000 вон-оор бичигдэж байдаг. Ийм өндөр системтэй байх нь сургуулийн орчимд хүүхдийн аюулгүй байдалд ноцтой зөрчил гаргах хэмжээний зүйл гардаггүй гэсэн үг. Тийм болхоор торгуулийг өндөр болгож өгвөл зөрчил гаргах нь буурна гэж би хувьдаа үзэж байна.

9-р асуулт: Торгуулийн 50% хөнгөлөлт (14 хоногт төлбөл) нь хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байна гэж үзэж байна вэ?

Хариулт: Дээрх хариулт нь энэ асуултанд бас хариулсан болно.

10-р асуулт: Таны хувьд ухаалаг камерын систем хэрэгжилт нь үр нөлөөтэй гэж үзэж байна уу? (Асуудал) Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ эсвэл шийдэл санал болговол юу байх вэ?

Хариулт: Үр нөлөөтэй гэж үзэж байгаа. Энэ оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн цагдаа нар зарим заалтаар биечилж торгуулийн арга хэмжээ тооцхоо больсон. Яагаад гэхээр, ухаалаг хяналтын камер ажиллаад эхэлсэн. Хотын хэмжээнд 174 уулзвар дээр 2400 гаруй камер ажиллаад эхэлсэн. Эннээс улбаалаад ai камер нь ямар нэгэн шалтгаан сонсохгүй, хэнийг ч ялгахгүй торгуулийн арга хэмжээ тооцож байгаа.

11-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын тогтолцоонд ямар өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?

Хариулт: Торгуулийн үнийн дүнг өсгөөд өгвөл мэдэгдэхүйц өөрчлөлт орох болов уу гэж бодож байна.

12-р асуулт: Гадаад улсын ямар туршлагыг Монголд нэвтрүүлэх боломжтой гэж бодож байна вэ?

Хариулт: БНСУ-ын замын хөдөлгөөний дүрмийг сайн мэдэхгүй байна. Тэгэхдээ маш эмх цэгц, замбраатай байдаг. Тэмдэг тэмдэглэгээ маш сайн ойлгомжтой байдаг.

Манайх улирлын чанартай байдаг тул өвлийн улиралд тэмдэг тэмдэглэгээ бараг харагдаггүй. Тийм болохоор тэмдэг тэмдэглэгээг сайжруулвал зүгээр байх гэж бодож байна.

13-р асуулт: Зөрчил бууруулахын тулд зөвхөн шийтгэлээс гадна өөр ямар арга хэмжээ хэрэгтэй вэ?

Хариулт: Миний хувьд бол соён гэгээрүүлэх гэж үздэг учраас зөрчил гаргасны дараа биш өмнө нь гэж ойлгодог учраас энэ төрлөөр жолооч нарт мэдээ мэдээллээр хангаж, урдчилсан сэргийлэх чиглэлээр юм хийх нь үр дүнтэй гэж боддог. Жолооч нарын мэдлэг боловсролыг илүү сайжруулж өгөх, хүн болгон зөрчлийн тухай хуулийг цээжлээгүй ч гэсэн мэддэг байх хэрэгтэй гэж үздэг.

14-р асуулт: Цаашид замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад хамгийн үр дүнтэй бодлого юу байх ёстой гэж та үзэж байна вэ?

Хариулт: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахын тулд ухаалаг камерын ажиллагааг илүү сайжруулах мөн торгуулийн хэмжээг ихэсгэх юм бол жолооч нарын дүрэм зөрчих багасна гэж үзэж байна. Аи болон өндөр торгуулийн дүнтэй 1 жил явахад жолооч нар дадчих байхаа гэж бодож байна.

Ярилцагч 2

1-р асуулт: Та хэдэн жил замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр ажиллаж байна вэ?

Хариулт: Сүүлийн 4 жил цагдаа зохицуулагчаар ажиллаж байна.

2-р асуулт: Өдөрт дунджаар хэдэн зөрчил илрүүлж, шийдвэрлэдэг вэ?

Хариулт: Дунджаар 30-40 зөрчил илрүүлдэг.

3-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын арга хэмжээ (торгууль, эрх хасах, баривчлах) жолооч нарын давтан зөрчил үйлдэхээс хэр үр дүнтэй сэргийлж байгаа гэж дүгнэж байна вэ? Яагаад?

Хариулт: Ер нь бол үр дүнтэй байгаа тэгэхдээ хаширдаггүй давтан зөрчил үйлдэгчид зөндөө байгаа.

4-р асуулт: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил болон оногдуулж буй торгуулийн хэмжээ нь танд хэр нийцтэй санагдаж байна вэ? Яагаад?

Хариулт: Ер нь бол надад бага санагддаг. Их хэмжээгээр торгоод яваад байвал замын хөдөлгөөний дүрмийн зөрчлүүд улам багасах байх гэж бодогддог.

5-р асуулт: Хууль хэрэгжүүлэх явцад ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ?

Хариулт: Жолооч нар өөрсдийн зөрчлийг мэдэхгүй, зөрчлийг нь тайлбарлаж өгөхөд өөдөөс хэрэлдэж маргалддаг, цагдаагийн алба хаагчдийг буруутгах талаас нь ярьж хөөрдөг асуудлууд их гардаг.

6-р асуулт: Зөрчил гаргасан жолооч нар шийтгэлээс зайлсхийх оролдлого гаргадаг уу?

Хариулт: Ер нь бол маш ихээр. Алба хаагчын энгэрийн камерийг харж байна. Энгэрийн камер зүүгээгүй үед хэл амаар доромжилж байна. Заримдаа өөрсдөө гуйж багасгаж торгуулиа бичүүлээд тэрэндээрээ гомдол гаргадаг.

7-р асуулт: Хяналт, шалгалтын тогтолцоо хангалттай түвшинд байна гэж үзэж байна уу?

Хариулт: Хангалттай гэж үзэж байгаа.

8-р асуулт: Мөрдөгдөж буй торгуулийн систем нь оновчтой хэрэгжиж байгаа гэж үзэж байна уу? Хэрвээ үгүй бол таны бодлоор ямар шинэчлэлт болон зохицуулалт шаардлагатай вэ?

Хариулт: Ер нь бол бүгд болж байгаа.

9-р асуулт: Торгуулийн 50% хөнгөлөлт (14 хоногт төлбөл) нь хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байна гэж үзэж байна вэ?

Хариулт: Ер бол эергээр нөлөөлж байгаа гэж үзэж байгаа. Хөнгөлөлтийн талаар мэдээллийг өгөхөд жолооч нар сайнаар хүлээн авч торгуулиа төлөх нь үр дүнтэй байгаа. Нөгөө талаасаа хөнгөлж байгаа боломжийг ашиглан давуу тал болгож байгаа тохиолдлууд ч бас их гарч ирж байгаа.

10-р асуулт: Таны хувьд ухаалаг камерын систем хэрэгжилт нь үр нөлөөтэй гэж үзэж байна уу? (Асуудал) Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ эсвэл шийдэл санал болговол юу байх вэ?

Хариулт: Энэ камерын арга хэмжээ нь байх юм бол цагдаагийн хэрэг байхгүй болж байгаа. Бид нарын ганц сайн торгодог зөрчил бол эгнээ байр буруу эзэлдэг, оношлогоо татвараа төлдөггүй, бид нар энэ зөрчлүүд дээр арга хэмжээ авдаг. Ухаалаг камер тус зөрчлүүдийг шийдэж байгаа гээд байгаа бүх юм нь хасагдаад бид цөөхөн зөрчил дээр зөрчлийн арга хэмжээ авч байгаа. Камераа сайн ажилуулж байгаа тохиолдолд цагдаагийн торгуулийг багасгах хэрэгтэй байгаа.

11-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын тогтолцоонд ямар өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?

Хариулт: Ер нь бол согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож байгаа хүмүүст илүү хатуу шийтгэл гаргамаар байгаа. Одоогийн арга хэмжээ арай зөөлдөөд байгаа. Тухайн зөрчил үйлдэгчид ухаарч байгаа юм байхгүй өдөрт маш ихээр баригдаж байгаа хэвээр байгаа.

12-р асуулт: Гадаад улсын ямар туршлагыг Монголд нэвтрүүлэх боломжтой гэж бодож байна вэ?

Хариулт: Гадаадаас цагдааг уулзварт оруулахгүйгээр гэрлэн дохиог удирддаг болмоор байна. Цагдаа нар байнгын хэл амаар доромжлуулж, зарим нь машинд мөргүүлж байна, гадаадын орныхон дандаа камераа хараад удирддаг системийг нэвтрүүлвэл дээр гэж үзэж байна.

13-р асуулт: Зөрчил бууруулахын тулд зөвхөн шийтгэлээс гадна өөр ямар арга хэмжээ хэрэгтэй вэ?

Хариулт: Цагдаагийн орон тоо дүүргүүдэд бага байгаатай холбогдуулан зөрчил илрүүлэлт бага байна. Цагдаагийн орон тоог нэмэгдүүлвэл зөрчилүүдээ хурдан шалгаж зөрчил тал дээр илүү анхаарч чадна.

14-р асуулт: Цаашид замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад хамгийн үр дүнтэй бодлого юу байх ёстой гэж та үзэж байна вэ?

Хариулт: Торгуулийн хэмжээг ихэсгэх эсвэл цагдаагийн албан хаагчийг ихэсгэвэл энэ уулзварын гараад дараагийн уулзвар дээр цагдаа байгаа гэдэг ойлголтоороо өмнө нь хийсэн зөрчилөө дараагийг дээр давтахгүй байх.

Ярилцагч 3:

1-р асуулт: Та хэдэн жил замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр ажиллаж байна вэ?

Хариулт: 12 жил замын цагдаагийн зохицуулагч

2-р асуулт: Өдөрт дунджаар хэдэн зөрчил илрүүлж, шийдвэрлэдэг вэ?

Хариулт: 7-8 зөрчил, зөвхөн зам тээврийн осол шийдвэрлэдэг

3-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын арга хэмжээ (торгууль, эрх хасах, баривчлах) жолооч нарын давтан зөрчил үйлдэхээс хэр үр дүнтэй сэргийлж байгаа гэж дүгнэж байна вэ? Яагаад?

Хариулт: Ер нь бол сэргийлж байгаа.

4-р асуулт: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил болон оногдуулж буй торгуулийн хэмжээ нь танд хэр нийцтэй санагдаж байна вэ? Яагаад?

Нийцтэй санагдаж байгаа.

5-р асуулт: Хууль хэрэгжүүлэх явцад ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ?

Хариулт: Өмнөх үеийг бодоход хамаагүй гайгүй болсон

6-р асуулт: Зөрчил гаргасан жолооч нар шийтгэлээс зайлсхийх оролдлого гаргадаг уу?

Хариулт: Ховор

7-р асуулт: Хяналт, шалгалтын тогтолцоо хангалттай түвшинд байна гэж үзэж байна уу?

Хариулт: Дутагдалтай талууд байгаа. Жишээ нь камерын хяналтын таарамж муу байгаа

8-р асуулт: Мөрдөгдөж буй торгуулийн систем нь оновчтой хэрэгжиж байгаа гэж үзэж байна уу? Хэрвээ үгүй бол таны бодлоор ямар шинэчлэлт болон зохицуулалт шаардлагатай вэ?

Хариулт: Ер нь бол торгуулийн хэмжээг болж байгаа гэж үзэж байгаа.

9-р асуулт: Торгуулийн 50% хөнгөлөлт (14 хоногт төлбөл) нь хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байна гэж үзэж байна вэ?

Хариулт: Сайнаар нөлөөлж байгаа. Хүнд зөрчил буюу согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох эсвэл эрхгүй хүн жолоодох мэт хэрэг дээр хөнгөлөлт үзүүлэхгүй нь бас зөв санагддаг.

10-р асуулт: Таны хувьд ухаалаг камерын систем хэрэгжилт нь үр нөлөөтэй гэж үзэж байна уу? (Асуудал) Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ эсвэл шийдэл санал болговол юу байх вэ?

Хариулт: Боломжын гэж үзэж байгаа.

11-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын тогтолцоонд ямар өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?

Хариулт: Одоогийн мөрдөгдөж буй хууль зүйн хариуцлага нь зөв зохистой ажиллаж байгаа тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзэж байна.

12-р асуулт: Гадаад улсын ямар туршлагыг Монголд нэвтрүүлэх боломжтой гэж бодож байна вэ?

Хариулт: Цагдаа зам дээр зогсож хийдэг зохицуулалтыг болиулж ухаалаг камерын системээр шийддэг болох хэрэгтэй байгаа.

13-р асуулт: Зөрчил бууруулахын тулд зөвхөн шийтгэлээс гадна өөр ямар арга хэмжээ хэрэгтэй вэ?

Хариулт: Урьдчилан сэргийлэх ажил явуулах хэрэгтэй байгаа.

14-р асуулт: Цаашид замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад хамгийн үр дүнтэй бодлого юу байх ёстой гэж та үзэж байна вэ?

Хариулт: Сар, улирал болгон явуулдаг замын хөдөлгөөний дүрмийг зөрчихгүй байх аянг илүү өргөн хүрээтэй хийдэг байх хэрэгтэй.

Ярилцагч 4:

1-р асуулт: Та хэдэн жил замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр ажиллаж байна вэ?

Хариулт: Цагдаа зохицуулагчаар 4 жил ажиллаж байгаа

2-р асуулт: Өдөрт дунджаар хэдэн зөрчил илрүүлж, шийдвэрлэдэг вэ?

Хариулт: Дунджаар 20-25 зөрчил илрүүлдэг

3-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын арга хэмжээ (торгууль, эрх хасах, баривчлах) жолооч нарын давтан зөрчил үйлдэхээс хэр үр дүнтэй сэргийлж байгаа гэж дүгнэж байна вэ? Яагаад?

Хариулт: Зөрчил гаргасан жолооч дээр зөрчлийн арга хэмжээ авдаг. Зам дээр илрүүлж арга хэмжээ авдаг болохлээр давтан зөрчихөөс сэргийлж байгаа гэж үзэж байна.

4-р асуулт: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил болон оногдуулж буй торгуулийн хэмжээ нь танд хэр нийцтэй санагдаж байна вэ? Яагаад?

Хариулт: Анх торгууль 5 мянга 10 мянга байдаг байсан нийгэм эдийн засгийн өсөлтийг дагаад өсөж байгаа тул нийцтэй санагдаж байгаа.

5-р асуулт: Хууль хэрэгжүүлэх явцад ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ?

Хариулт: Зөндөө хүндрэл бэрхшээл тулгардаг. Жишээ нь гаргасан зөрчилөө хүлээн зөвшөөрөхгүй байх, зөрчил үйлдсэнээ мэдэж байж зогсохгүй явах, хэрүүл маргаан хийх гэх мэт ухамсаргүй үйлдэл гаргадаг.

6-р асуулт: Зөрчил гаргасан жолооч нар шийтгэлээс зайлсхийх оролдлого гаргадаг уу?

Хариулт: 5р асуултад хариулсан хариулт уг асуултад бас хариулсан тул ярилцагчаас дахин асуугаагүй болно.

7-р асуулт: Хяналт, шалгалтын тогтолцоо хангалттай түвшинд байна гэж үзэж байна уу?

Хариулт: Хяналт шалгалт хангалттай байгаа. Байнга хяналт шалгалт тавигдаж байдаг.

8-р асуулт: Мөрдөгдөж буй торгуулийн систем нь оновчтой хэрэгжиж байгаа гэж үзэж байна уу? Хэрвээ үгүй бол таны бодлоор ямар шинэчлэлт болон зохицуулалт шаардлагатай вэ?

Хариулт: Торгуулийн тогтолцоо оновчтой. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар заалтаар гаргасан зөрчилд нь тааруулаад торгодог тул сайн хэрэгжиж байгаа гэж үзэж байна.

9-р асуулт: Торгуулийн 50% хөнгөлөлт (14 хоногт төлбөл) нь хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байна гэж үзэж байна вэ?

Хариулт: Маш их нөлөөлж байгаа. Хөнгөлөлт үзүүлж байгаа тул жолоочдын торгууль төлөлт нь ихсэж гүйцэтгэлд сайнаар нөлөөлж байгаа.

10-р асуулт: Таны хувьд ухаалаг камерын систем хэрэгжилт нь үр нөлөөтэй гэж үзэж байна уу? (Асуудал) Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ эсвэл шийдэл санал болговол юу байх вэ?

Хариулт: Сайнаар нөлөөлж байгаа. Замын цагдаагийн зохицуулагч зам дээр зохицуулалт хийж байх үед зөвхөн зохицуулагчийн дүрмээр хөдөлгөөнд орно гэж заасан байдаг. Цагдаа зам дээр зохицуулалт хийх үедээ замын хөдөлгөөний удирдлагын төвтэй холбогдож тухайн уулзварын А1 камерийг унтраалгадаг. Харин жолоочид энэ тухай мэдэхгүйн улмаас А1 камерт торгуулна гэж бодож зам зохицуулж буй цагдаагийн шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолууд гардаг.

11-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын тогтолцоонд ямар өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?

Хариулт: Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хүн дээр хүлээлгэх хариуцлагыг илүү хүнд хэлбэрийн болговол илүү нөлөөтэй.

12-р асуулт: Гадаад улсын ямар туршлагыг Монголд нэвтрүүлэх боломжтой гэж бодож байна вэ?

Хариулт: Жишээ нь азийн хөгжсөн орнуудаас жишиг авах ёстой. Жишээ нь бусад хөгжсөн улс орнууд цагдаагаар зам дээр зохицуулалт хийлгэхээ больсон байна.

13-р асуулт: Зөрчил бууруулахын тулд зөвхөн шийтгэлээс гадна өөр ямар арга хэмжээ хэрэгтэй вэ?

Хариулт: Ердөөсөө урьдчилан сэргийлэх ажлыг сайн хийх ёстой.

14-р асуулт: Цаашид замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад хамгийн үр дүнтэй бодлого юу байх ёстой гэж та үзэж байна вэ?

Хариулт: Торгуулийн хэмжээг өндөрсгөж чангатгах хэрэгтэй. Торгуулийн хэмжээг их болгох тусам жолооч нарын давтан зөрчих зөрчил багасна гэж үзэж байна.

Ярилцагч 5:

1-р асуулт: Та хэдэн жил замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр ажиллаж байна вэ?

Хариулт: Цагдаа зохицуулагчаар 5 жил ажиллаж байгаа

2-р асуулт: Өдөрт дунджаар хэдэн зөрчил илрүүлж, шийдвэрлэдэг вэ?

Хариулт: Дунджаар 10-20 зөрчил илрүүлдэг

3-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын арга хэмжээ (торгууль, эрх хасах, баривчлах) жолооч нарын давтан зөрчил үйлдэхээс хэр үр дүнтэй сэргийлж байгаа гэж дүгнэж байна вэ? Яагаад?

Хариулт: Ер нь бол 50 хувьтай тэнцэхүйц гэж дүгнэж байна.

4-р асуулт: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил болон оногдуулж буй торгуулийн хэмжээ нь танд хэр нийцтэй санагдаж байна вэ? Яагаад?

Хариулт: Жолоодох эрхгүй болгон согтуугаар тээврийн хэрэгсэл барьсан жолоочид бол нийцтэй. Яг замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, жишээ нь, эгнээ байр буруу эзэлсэн, аюулгүйн бүс зүүгээгүй гэх мэтчилэн тулгардаг зөрчлүүдийн хувьд торгуулийн хэмжээ сул байгаа.

5-р асуулт: Хууль хэрэгжүүлэх явцад ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ?

Хариулт: Хууль эрх зүйн актыг нь сайжруулж боловсронгуй болгох хэрэгтэй.

6-р асуулт: Зөрчил гаргасан жолооч нар шийтгэлээс зайлсхийх оролдлого гаргадаг уу?

Хариулт: Ихэвчлэн

7-р асуулт: Хяналт, шалгалтын тогтолцоо хангалттай түвшинд байна гэж үзэж байна уу?

Хариулт: Дунд зэрэг

8-р асуулт: Мөрдөгдөж буй торгуулийн систем нь оновчтой хэрэгжиж байгаа гэж үзэж байна уу? Хэрвээ үгүй бол таны бодлоор ямар шинэчлэлт болон зохицуулалт шаардлагатай вэ?

Хариулт: Торгуулийн системийн хувьд болж байгаа. Бусад орноос судалж зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээг монгол улсад нэвтрүүлэх. Жишээ нь манай улсын зорчих хэсэг дээр түр буюу удаан зогсох дээр торгодог шийтгэл гэх мэт. Хуучин манайд зөрчлийн онооны системтэй байсан. Уг систем нь их боломжын байсан. Оноо хасуулахгүйн тулд жолооч нар заавал бүсээ зүүх гэх мэт оноогоо алдахаас сэргийлдэг байсан. Онооны системийг болиулснаас хойш жолооч нар торгуулийн дүнг хөнгөлөлттэйгээр төлж, дүрэм зөрчих давтамж багасахаа больсон.

9-р асуулт: Торгуулийн 50% хөнгөлөлт (14 хоногт төлбөл) нь хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байна гэж үзэж байна вэ?

Хариулт: Сөргөөр нөлөөлөх зүйлүүд байна. Зөрчил гаргасан жолооч хөнгөлөлттэй төлчих юм чинь гэсэн хандлагад орж байгаа харагдаад байгаа.

10-р асуулт: Таны хувьд ухаалаг камерын систем хэрэгжилт нь үр нөлөөтэй гэж үзэж байна уу? (Асуудал) Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ эсвэл шийдэл санал болговол юу байх вэ?

Хариулт: Аi камерын систем үр нөлөөтэй байгаа. Тэгэхдээ ухаалаг камерын систем ажиллахын зэрэгцээ уулзвар гарцан дээр зогсож зөрчил илрүүлж байгаа алба хаагч нарын зөрчлийн илрүүлэлт харьцангуй багассан.

11-р асуулт: Одоогийн хууль зүйн хариуцлагын тогтолцоонд ямар өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?

Хариулт: Боловсронгуй болгох, зарим зөрчил дээр оногдуулах шийтгэлийг эргэн харах хэрэгтэй байх гэж боддог.

12-р асуулт: Гадаад улсын ямар туршлагыг Монголд нэвтрүүлэх боломжтой гэж бодож байна вэ?

Хариулт: Зам ашиглалттай холбоотой туршлага судалж, хуулийг нь боловсронгуй болгож өгөх хэрэгтэй байх.

13-р асуулт: Зөрчил бууруулахын тулд зөвхөн шийтгэлээс гадна өөр ямар арга хэмжээ хэрэгтэй вэ?

Хариулт: Урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгтэй.

14-р асуулт: Цаашид замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад хамгийн үр дүнтэй бодлого юу байх ёстой гэж та үзэж байна вэ?

Хариулт: Эхлээд манай улсын замын байгууламжийг шинээр төлөвлөж хэрэгжүүлвэл жолооч нарын дүрэм зөрчих хандлага багасах болов уу гэж бодож байна.

Ярилцлагын судалгааны дүгнэлт:

Замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр ажиллаж буй алба хаагчидтай хийсэн ярилцлагын үр дүнгээс харахад Монгол Улсад мөрдөгдөж буй хууль зүйн хариуцлагын тогтолцоо тодорхой хэмжээнд үр нөлөөтэй боловч төгс хэрэгжиж чадахгүй байгаа нь ажиглагдаж байна. Ихэнх ярилцагчид өдөрт дунджаар 10–40 орчим

зөрчил илрүүлж, шийдвэрлэдэг бөгөөд зөрчил ихэвчлэн давтагдах шинжтэй байгааг онцолсон байна . Энэ нь жолооч нарын хууль сахих хандлага сул байгааг илтгэж байна.

Хууль зүйн хариуцлагын хувьд торгууль, жолоодох эрх хасах, баривчлах зэрэг арга хэмжээ нь тодорхой хэмжээнд сэргийлэх нөлөө үзүүлдэг ч давтан зөрчил бүрэн бууруулж чадахгүй байгааг ихэнх оролцогчид дурдсан. Ялангуяа согтуугаар жолоо барих зэрэг ноцтой зөрчилд хатуу арга хэмжээ авч байгаа нь эерэг нөлөөтэй боловч энгийн зөрчлүүд дээрх торгуулийн хэмжээ хангалтгүй гэж үзэх хандлага давамгайлж байна. Зарим ярилцагчийн үзэж байгаагаар бага хэмжээний торгууль, мөн 14 хоногийн дотор төлбөл 50 хувиар хөнгөлөх зохицуулалт нь жолооч нарт зөрчлийг “тооцоолсон байдлаар” давтан үйлдэх сэдэл болж байна .

Нөгөө талаас, хөнгөлөлтийн систем нь торгуулийн төлөлтийг нэмэгдүүлж, хэрэгжилтийг сайжруулж байгаа эерэг талтай гэж зарим оролцогчид үзсэн нь энэ асуудалд хоёрдмол нөлөө байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, уг зохицуулалт нь нэг талаар хэрэгжилтийг дэмждэг боловч нөгөө талаар урьдчилан сэргийлэх үр нөлөөг сулруулж байна.

Хууль хэрэгжүүлэх явцад тулгарч буй гол хүндрэлүүдэд жолооч нар зөрчлөө хүлээн зөвшөөрөхгүй байх, хэл амаар маргах, шийтгэлээс зайлсхийх оролдлого гаргах зэрэг асуудлууд түгээмэл байна. Энэ нь зөвхөн хууль эрх зүйн зохицуулалтаас гадна иргэдийн эрх зүйн ухамсар, соёлтой шууд холбоотойг харуулж байна .

Хяналт, шалгалтын тогтолцооны хувьд ихэнх ярилцагчид хангалттай гэж үзсэн боловч камерын хяналтын чанар, хүртээмж зарим тохиолдолд дутагдалтай байгааг дурдсан. Харин ухаалаг камерын системийг нийтээр нь үр нөлөөтэй гэж үнэлж байгаа бөгөөд хүний оролцоог багасгаж, зөрчлийг илүү шударга, ялгаварлалгүй илрүүлэх давуу талтай гэж үзэж байна.

Цаашид замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад дараах чиглэлүүдийг онцлон шаардлагатай гэж үзэж байна. Үүнд: торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх, хөнгөлөлтийн бодлогыг эргэн харах, ухаалаг камерын системийг өргөжүүлэх, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, мөн жолооч нарын мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн зарим ярилцагчдын зүгээс онооны системийг дахин нэвтрүүлэх нь давтан зөрчлийг бууруулахад эерэг нөлөөтэй байж болохыг онцолсон нь анхаарал татаж байна.

Дүгнэхэд, нийслэлд мөрдөгдөж буй замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлага нь суурь тогтолцооны хувьд бүрдсэн боловч торгуулийн бодлого, хэрэгжилтийн үр нөлөө, урьдчилан сэргийлэх ажил зэрэгт цаашид сайжруулах шаардлага байгааг энэхүү ярилцлагын судалгаа харуулж байна.

Бүлгийн дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын тогтолцоо (торгууль, жолоодох эрх хасах, баривчлах) нь үндсэндээ бүрдсэн боловч түүний хэрэгжилт, урьдчилан сэргийлэх үр нөлөө хангалттай түвшинд хүрэхгүй байна. Ярилцлагын судалгаагаар зөрчил давтагдах хандлага өндөр байгаа нь жолооч нарын хууль сахих соёл, хандлага сул байгааг илтгэж байгаа бол асуулгын судалгаагаар зөрчил өргөн тархсан, ялангуяа хотын түгжрэл, замын ачааллаас шалтгаалсан зөрчил давамгайл байгааг баталж байна.

Хууль зүйн хариуцлагын арга хэмжээнүүдээс жолоодох эрх хасах болон баривчлах шийтгэл нь илүү үр нөлөөтэй гэж үнэлэгдсэн бол торгуулийн арга хэмжээ нь дунд түвшний нөлөөтэй байгаа нь тогтоогдсон. Ялангуяа торгуулийн хэмжээ бага, мөн 14 хоногийн дотор төлбөл 50 хувиар хөнгөлөх зохицуулалт нь нэг талаар төлөлтийг нэмэгдүүлдэг ч нөгөө талаар зөрчлийг “тооцоолж үйлдэх” хандлагыг бий болгож, урьдчилан сэргийлэх ач холбогдлыг сулруулж байна. Иймд торгуулийн бодлогыг үр нөлөөний үүднээс дахин үнэлэх шаардлагатай байна.

Мөн судалгаагаар замын хөдөлгөөний зөрчил нь зөвхөн хувь хүний буруутай үйлдлээс бус, замын ачаалал, зохион байгуулалт, орчны хүчин зүйлсээс ихээхэн хамаарч байгааг харуулсан. Иймд зөрчлийг бууруулахад зөвхөн хууль зүйн хариуцлага хангалтгүй бөгөөд замын дэд бүтэц, зохион байгуулалт, хяналтын тогтолцоо, жолоочийн боловсрол зэрэг олон талт арга хэмжээг хослуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн ухаалаг камер, хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын систем нь зөрчил илрүүлэх, хүний оролцоог багасгах, шударга байдлыг хангах давуу талтай ч техникийн алдаа, нөхцөл байдлыг бүрэн үнэлэх боломжгүй зэрэг сул талууд ажиглагдаж байна. Иймд автомат болон хүний хяналтыг хослуулсан хэлбэр илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Эцэст нь дүгнэхэд, замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахын тулд торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх, хөнгөлөлтийн бодлогыг оновчтой болгох, хяналтын технологийг өргөжүүлэх, замын зохион байгуулалтыг сайжруулах, мөн жолооч нарын эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх зэрэг цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэснээр хууль зүйн хариуцлагын бодит үр нөлөө нэмэгдэж, замын хөдөлгөөний аюулгүй байдалд эерэг өөрчлөлт гарна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэж буй хууль зүйн хариуцлагын үр нөлөөг судалж, түүний хэрэгжилт, жолоочийн зан үйлд үзүүлж буй нөлөөлөл, мөн БНСУ, АНУ-ын туршлагатай харьцуулан дүгнэхийг зорьсон. Судалгааны хүрээнд Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, асуулга болон ярилцлагын судалгааны үр дүн, гадаад улсын туршлагыг нэгтгэн авч үзэхэд замын хөдөлгөөний зөрчлийг бууруулахад зөвхөн шийтгэл ногдуулах бус, харин хяналт, хэрэгжилт, жолоочийн ухамсар, замын зохион байгуулалт, технологийн шийдлийг хамтад нь авч үзэх шаардлагатай байна.

Монгол Улсын хувьд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үндсэн төрөл болох торгууль, жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл хууль тогтоомжийн түвшинд бүрдсэн байна. Гэвч эдгээр хариуцлагын арга хэмжээний бодит хэрэгжилт, урьдчилан сэргийлэх нөлөө хангалттай түвшинд хүрэхгүй байгаа нь судалгааны явцад тодорхой харагдлаа. Ялангуяа сүүлийн жилүүдэд замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн тоо буурахгүй, өсөх хандлагатай байгаа нь одоогийн хариуцлагын тогтолцоо жолоочийн зан үйлд хангалттай нөлөөлж чадахгүй байгааг харуулж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд торгуулийн шийтгэл нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг боловч жолоочийн зан үйлд үзүүлэх нөлөө харьцангуй сул байна. Монгол Улсын өрхийн сарын дундаж орлоготой харьцуулахад хамгийн бага торгуулийн хэмжээ 0.36 хувийг эзэлж байгаа нь АНУ-ын 0.72 хувь, БНСУ-ын 0.74 хувьтай харьцуулахад бараг хоёр дахин бага байна. Энэ нь Монгол Улсад торгуулийн санхүүгийн нөлөөлөл сул, зөрчил гаргагчид бодит дарамт үүсгэх чадвар хангалтгүй байж болзошгүйг харуулж байна. Иймд торгуулийн хэмжээг зөвхөн мөнгөн дүнгээр нь бус, иргэдийн орлогын түвшин, зөрчлийн аюулын шинж, давтамжтай уялдуулан дахин үнэлэх шаардлагатай.

Мөн 14 хоногийн дотор торгуулиа төлсөн тохиолдолд 50 хувиар хөнгөлөх зохицуулалт нь нэг талаас торгуулийн төлөлтийг нэмэгдүүлэх давуу талтай боловч нөгөө талаас зөрчил гаргасан жолооч хариуцлагыг хөнгөнөөр хүлээн авах, торгуулийг урьдчилан “тооцоолж” зөрчил үйлдэх хандлагыг бий болгох эрсдэлтэй байна. Иймээс уг зохицуулалтыг зөвхөн төлбөр барагдуулах үр ашиг талаас нь бус, зөрчил бууруулах болон урьдчилан сэргийлэх бодит нөлөө талаас нь дахин авч үзэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Жолоодох эрх хасах болон баривчлах шийтгэл нь торгуультай харьцуулахад жолоочид илүү хүчтэй нөлөө үзүүлэх боломжтой арга хэмжээ болох нь асуулга, ярилцлагын судалгаагаар тодорхойлогдсон. Гэхдээ эдгээр шийтгэлийг бүх зөрчилд ижил байдлаар хэрэглэхээс илүүтэйгээр давтан, ноцтой, бусдад аюул учруулах өндөр эрсдэлтэй зөрчилд ялгамжтайгаар хэрэглэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, хариуцлагын бодлого нь зөрчлийн шинж, давтамж, хор уршиг, нийгмийн аюулын түвшинд тохирсон байх шаардлагатай.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд БНСУ-ын туршлага нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зөвхөн шийтгэл бус, хяналт, технологи, мэдээллийн нэгдсэн сан, жолоочийн боловсролыг уялдуулсан цогц тогтолцоо үр дүнтэй болохыг харуулж байна. Автомат хяналтын систем, зөрчил илрүүлэх өндөр магадлал, давтан зөрчил гаргагчдад чиглэсэн тусгай арга хэмжээ нь жолоочийн хууль сахих хандлагад бодитоор нөлөөлдөг байна. Харин АНУ-ын хувьд торгууль, онооны систем, жолоодох эрхийн хязгаарлалт, шүүхийн хяналт, даатгалын төлбөрийн өсөлт зэрэг олон талт үр дагавар нь жолоочид урт хугацааны эдийн засгийн болон эрх зүйн нөлөөлөл үзүүлдэг онцлогтой байна.

Эдгээрээс дүгнэвэл Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахын тулд зөвхөн торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх нь хангалтгүй юм. Харин шийтгэлийн зайлшгүй хэрэгжилтийг хангах, хяналт илрүүлэлтийн тогтолцоог сайжруулах, ухаалаг камер болон хиймэл оюун ухаанд суурилсан хяналтыг зохистой нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн сан болон дүн шинжилгээнд тулгуурласан бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Гэхдээ технологид суурилсан хяналтыг нэвтрүүлэхдээ техникийн алдаа, нөхцөл байдлыг бүрэн үнэлэх боломжгүй байдал, иргэдийн итгэлцэл, мэдээллийн аюулгүй байдлыг давхар анхаарч, хүний хяналттай хослуулсан хэлбэрээр хөгжүүлэх нь илүү оновчтой.

Мөн замын хөдөлгөөний зөрчил нь зөвхөн жолоочийн буруутай үйлдлээс бус, замын түгжрэл, ачаалал, зохион байгуулалт, дэд бүтэц, хяналтын хүртээмж, жолоочийн эрх зүйн мэдлэг, хандлага зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Иймд зөрчлийг бууруулах бодлого нь зөвхөн шийтгэл ногдуулах хүрээнд хязгаарлагдахгүй, замын зохион байгуулалтыг сайжруулах, жолоочийн боловсрол, ухамсрыг дээшлүүлэх, давтан зөрчил гаргагчдад чиглэсэн ялгамжтай арга хэмжээ авах зэрэг олон талт арга хэмжээг хамарсан байх шаардлагатай.

Эцэст нь дүгнэхэд, замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөө нь зөвхөн шийтгэлийн хатуу байдал, торгуулийн хэмжээнээс хамаарахгүй байна. Харин тухайн хариуцлага бодитой хэрэгжиж байгаа эсэх, зөрчил илрүүлэх магадлал хэр өндөр байгаа, жолоочийн зан үйлд хэрхэн нөлөөлж байгаа, мөн төрийн бодлого хяналт, боловсрол, технологи, замын зохион байгуулалттай хэр уялдаж байгаагаас шууд хамаарч байна. Иймээс Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахын тулд хууль зүйн хариуцлагын тогтолцоог цогц байдлаар шинэчилж, хэрэгжилт, хяналт, боловсрол, технологи, дэд бүтцийн арга хэмжээг харилцан уялдаатай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны дүгнэлтэд үндэслэн Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөөг нэмэгдүүлэх, зөрчлийг бууруулах, жолоочийн хууль сахих зан үйлд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Торгуулийн хэмжээг бодит үр нөлөөтэй уялдуулан шинэчлэх

Монгол Улсад замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд оногдуулж буй зарим торгуулийн хэмжээ нь сарын өрхийн дундаж орлогын түвшинтэй харьцуулахад харьцангуй бага байгаа нь жолоочид нөлөөлөх санхүүгийн нөлөөллийг сулруулж байна. Иймд торгуулийн хэмжээг зөвхөн тогтмол мөнгөн дүнгээр бус, зөрчлийн шинж, давтамж, учруулж болзошгүй хор уршиг, нийгмийн аюулын түвшинтэй уялдуулан шинэчлэх шаардлагатай. Тухайлбал хурд хэтрүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, улаан гэрлээр нэвтрэх зэрэг өндөр эрсдэлтэй зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй.

2. Торгуулийн 50 хувийн хөнгөлөлтийн зохицуулалтыг цуцлах

Торгуулийг 14 хоногийн дотор төлсөн тохиолдолд 50 хувиар хөнгөлөх зохицуулалт нь торгуулийн төлөлтийг нэмэгдүүлэх давуу талтай боловч зөрчил гаргасан жолоочид хариуцлагыг хөнгөнөөр хүлээн авах, зөрчлийг “тооцоолж үйлдэх” сөрөг хандлага бий болгох эрсдэлтэй байна. Иймд уг зохицуулалтыг бүх төрлийн зөрчилд адил хэрэглэхээс татгалзаж, давтан болон ноцтой зөрчилд хөнгөлөлт үзүүлэхгүй байх, эсвэл зөвхөн анх удаа, хөнгөн шинжтэй зөрчил гаргасан тохиолдолд хязгаарлагдмал байдлаар хэрэглэх хувилбарыг дэвшүүлэх шаардлагатай.

3. Давтан зөрчил үйлдсэн жолоочид чиглэсэн тусгай хариуцлагын бодлого хэрэгжүүлэх

Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад давтан зөрчил үйлдсэн жолоочид чиглэсэн тусгай арга хэмжээ чухал ач холбогдолтой. Иймд нэг төрлийн зөрчлийг олон удаа үйлдсэн, эсвэл богино хугацаанд хэд хэдэн удаа зөрчил гаргасан жолоочид ногдуулах хариуцлагыг шаталсан хэлбэрээр нэмэгдүүлэх нь зүйтэй. Үүнд торгуулийн хэмжээг өсгөх, жолоодох эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах, сургалтад хамруулах, шаардлагатай тохиолдолд сэтгэл зүй, зан үйлийн сургалт авах зэрэг арга хэмжээг тусгаж болно.

4. Шийтгэлийн зайлшгүй хэрэгжилтийг хангах

Хууль зүйн хариуцлагын үр нөлөө нь зөвхөн шийтгэлийн хатуу байдлаас бус, тухайн шийтгэл зайлшгүй хэрэгжих эсэхээс шууд хамаардаг. Иймд зөрчил илрүүлсэн тохиолдолд хариуцлага заавал ногдох, ногдуулсан торгууль, шийтгэл бодитой биелэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Торгуулиа төлөхгүй удаашруулах, шийтгэлээс

зайлсхийх, бүртгэлийн сул талыг ашиглах боломжийг багасгахын тулд тухайн жолоочийн торгуулын хэмжээ тодорхой хэмжээний үнийн дүнг давсан тохиолдолд захиргааны хэргийн шүүхээр торгуулийг албадан төлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.

5. Ухаалаг камер, хиймэл оюун ухаанд суурилсан хяналтыг өргөжүүлэх

Замын хөдөлгөөний зөрчлийг илрүүлэхэд хүний нөөц дангаараа хангалтгүй тул ухаалаг камер, хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын системийг үе шаттайгаар өргөжүүлэх шаардлагатай. Ийм систем нь зөрчлийг шуурхай илрүүлэх, хүний оролцоог багасгах, хяналтын хүртээмжийг нэмэгдүүлэх давуу талтай. Гэхдээ автомат системийн шийдвэрийг шууд эцсийн шийдвэр болгох бус, техникийн алдаа, тухайн нөхцөл байдлыг буруу үнэлэх эрсдэлээс сэргийлж хүний хяналттай хослуулсан хэлбэрээр хэрэгжүүлэх нь зүйтэй.

6. Жолоочийн эрх зүйн мэдлэг, ухамсар, хандлагыг дээшлүүлэх

Судалгааны үр дүнгээс харахад замын хөдөлгөөний зөрчил нь зөвхөн хяналт сул байгаагаас бус, жолоочийн хууль сахих соёл, хариуцлагын ойлголт, бусдын аюулгүй байдлыг хүндэтгэх хандлагатай шууд холбоотой байна. Иймд жолоочийн сургалт, давтан сургалт, олон нийтийн мэдээлэл сурталчилгаа, сургуулийн наснаас эхэлсэн замын хөдөлгөөний боловсролыг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа торгууль төлөхөөс илүүтэй зөрчил гаргаснаар хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болох хор уршгийг ойлгуулахад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил хэрэгтэй байна.

7. Гадаад улсын туршлагыг Монгол Улсын нөхцөлд тохируулан нэвтрүүлэх

БНСУ болон АНУ-ын туршлагаас харахад замын хөдөлгөөний зөрчлийг бууруулахад дан ганц торгууль бус, хяналт, мэдээллийн сан, даатгал, жолоочийн бүртгэл, давтан зөрчилд чиглэсэн бодлого зэрэг олон талт арга хэмжээ үр дүнтэй байна. Иймд Монгол улс эдгээр туршлагыг шууд нэвтрүүлж хэрэгжүүлэх бус, дотоод эрх зүйн орчин, эдийн засгийн нөхцөл, замын хөдөлгөөний ачаалал, иргэдийн орлогын түвшинтэй уялдуулан нутагшуулах нь зүйтэй. Тухайлбал жолоочын хариуцлагын даатгал нь ноцтой, өндөр эрсдэлтэй давтан зөрчил үйлдсэн эсэх, богино хугацаанд олон удаагийн давтамжтай зөрчил гаргасан эсвэл оногдуулсан торгуулийг хугацаанд төлөөгүй зэргээс хамааран заалт бүрт тогтоосон дүнгээр харьцангуй адил нэмэгддэг зохицуулалтыг нэвтрүүлэх хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээрх:

Амарсанаа, Ц. (2024). *Захиргааны эрх зүй, ерөнхий анги*. Улаанбаатар.

Ганболд, Б. (2018). *Зөрчлийн эрх зүй*. Улаанбаатар.

Замын хөдөлгөөний удирдлагын төв. (2026 оны 01 29). *Замын хөдөлгөөний удирдлагын төв*. <https://ubtraffic.mn/news/82687>-ээс Гаргасан

Одгэрэл, П. (2008). *Захиргааны эрх зүйн ерөнхий анги*.

Тээврийн прокурорын газар. (2025 оны 08 19). *Тээврийн прокурорын газар*. <https://trpo.prosecutor.mn/post/112753>-ээс Гаргасан

Тээврийн цагдаагийн алба. (2020-2025). *Монгол улсад бүртгэгдсэн Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл*. Улаанбаатар: Тээврийн цагдаагийн алба.

Тээврийн цагдаагийн алба. (2023). *Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл*.

Тээврийн цагдаагийн алба. (2023 оны 05 23). *Тээврийн цагдаагийн алба*. Гаргасан 2026, <https://transportation.police.gov.mn/a/4127>-аас

Тээврийн цагдаагийн алба. (2024). *Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл*.

Тээврийн цагдаагийн алба. (2025). *Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, статистик үзүүлэлтийн эмхэтгэл*.

Үндэсний статистикийн хороо. (огноо байхгүй). *Үндэсний статистикийн хороо*. https://www.nso.mn/mn/statcate/table-view/Society%2C%20development/Household%20income%20and%20expenditure/D_T_NSO_1900_001V1.px

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (огноо байхгүй). <https://legalinfo.mn/mn/detail/11224>-ээс Гаргасан

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (огноо байхгүй). *Зөрчлийн тухай хууль*. <https://legalinfo.mn/mn/detail/12695>-ээс Гаргасан

Ikon. (2026 оны 01 01). *Ikon*. <https://ikon.mn/n/3kgx>

Гадаад хэлээрх:

7th Judicial Circuit Court, Clay county, Missouri. (2024 оны 01 01). <https://www.circuit7.net/traffic/violation-fines>-ээс Гаргасан

Abroodi, M., Kashfi, S., & Hosseini, T. (2018). *The effect of new law on traffic violations on. Tehran*.

Bruner, A. (2025 оны 10 20). *Oktrafficticketdefense*. <https://oktrafficticket.com/post/getting-a-traffic-ticket-can-cost-you-much-more-in-insurance-penalties-than-the-initial-fine/>-ээс Гаргасан

- Devendorf, J. (2025 оны 06 25). *Super Lawyers*.
<https://www.superlawyers.com/resources/traffic-violations/what-happens-if-you-ignore-a-traffic-ticket/#:~:text=Ignoring%20a%20traffic%20ticket%20can,keep%20your%20driving%20record%20clear.>
- Easy law. (огноо байхгүй). *Easy law*.
<https://www.easylaw.go.kr/CSM/CsmOvSave.laf?csmSeq=740&ccfNo=3&cciNo=1&cnpClsNo=1-ээс Гаграсан>
- El Mehdi Ben Laoulaa, O. E. (2023). *Traffic violations analysis: Identifying risky areas and* .
- INSHUR. (2025 оны 01 23). *INSHUR*. <https://inshur.com/en-gb/blog/ai-speed-cameras-what-drivers-need-to-know#:~:text=AI%20speed%20cameras%20use%20cutting,low%20visibility%20or%20heavy%20traffic.>
- insurance, G. (2025). *General insurance*. <https://www.generalcentralinsurance.com/blog/car-insurance/the-impact-of-traffic-violations-on-motor-insurance-premiums-ээс Гаграсан>
- IREX. (2026 оны 04 22). *Detecting Traffic Violations: Governance-First AI for Enforcement Workflows*. <https://irex.ai/blog/tpost/bmbkzkdms1-detecting-traffic-violations-governance>
- KOREA PRO. (2026). *KOREA PRO*. <https://koreapro.org/2026/02/south-koreas-household-incomes-rise-but-real-consumption-slips-in-2025/>
- Melissa Kollar, Z. S. (2025). *Income in the United States*. <https://www2.census.gov/library/publications/2025/demo/p60-286.pdf-ээс Гаграсан>
- Motuzov, N. (огноо байхгүй). *american butler*.
https://americanbutler.ru/en/useful/lifestyle/traffic-violation-fines?srsId=AfmBOoprzaMJ06iMm2r-Yw96apebmC_keXjGdweOmjvQdkEGMmRzpQrm
- Oh-Eun, K. (2025 оны 04 17). *ChosunBiz*. <https://biz.chosun.com/en/en-society/2025/04/17/ZUI5GSQK6BCMFGLO3ZVQS5O3NE/>
- OPTTRAFFIC. (2024 оны 08 02). <https://optraffic.com/blog/driving-penalties-in-the-usa/>
- Ph.D, J.-G. K. (2002). *Changes of speed and safety by automated speed enforcement systems*.
- Riordan, M. (2023 оны 08 23). *Reflaw*. <https://reflaw.org/us-states-have-the-strictest-and-least-strict-driving-laws/>

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Асуулгын судалгаа

Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль эрх зүйн хариуцлагын үр нөлөөны судалгаа

Энэхүү судалгааны зорилго нь “Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөөг судлах нь” сэдэвт судалгааны хүрээнд явагдаж байна. Таны өгсөн хариулт зөвхөн судалгааны зорилгоор ашиглагдах бөгөөд хувь хүний мэдээллийг чандлан хадгалах болно. Манай судалгаанд хамрагдаж байгаа таньд гүнээ талархал илэрхийлье!

1. Таны хүйс

- Эрэгтэй
- Эмэгтэй

2. Таны нас

- 18-24
- 24-26
- 26-30
- 30-34
- 34-38
- 38-42
- 42-50
- 50 ба түүнээс дээш

3. Таны боловсрол

- Бүрэн дунд
- Дээд
- Магистр болон түүнээс дээш

4. Та аль дүүрэгт амьдардаг вэ?

- Баянзүрх
- Баянгол
- Сүхбаатар
- Сонгинохайрхан
- Хан-Уул
- Чингэлтэй
- Багануур
- Багахангай
- Налайх

Та жолооч болоод хэдэн жил болж байгаа вэ?

- 1 жилээс бага
- 1-3 жил

- 4-7 жил
- 8-10 жил
- 10 жилээс дээш

Та тээврийн хэрэгсэлээр замын хөдөлгөөнд ямар давтамжтай оролцдог вэ?

- Өдөр бүр
- Долоо хоногт 1-2 удаа
- Долоо хоногт 3-5 удаа

Та ихэвчлэн ямар зорилгоор тээврийн хэрэгсэл жолооддог вэ?

- Хувийн хэрэгцээ
- Ажил, албан хэрэгцээ

Та өөрийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг үнэлнэ үү.

- Сайн
- Дунд
- Муу

Та замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж байсан эсэх.

- Тийм
- Үгүй

Хэрэв тийм бол ямар төрлийн зөрчил гаргаж байсан бэ?

- Хориглосон газар ухрах, буцаж эргэх
- Дугаарын хязгаарлалттай өдөр зорчих
- Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр байрлан явсан (1-р эгнээ)
- Уулзвар нэвтрэх журам зөрчих
- Замын аюулгүй байдал хангах үүрэг зөрчих
- Зорчих хэсэг дээр түр, удаан зогсоох журам зөрчих
- Явган хүний гарц дээр, замын тэмдгээр зөвшөөрөгдөөгүй явган хүний зам дээр зогсох
- Тээврийн хэрэгсэлээ техникийн үзлэгт хамруулаагүй
- Хурд хэтрүүлэх
- Замын тэмдэг, тэмдэглэгээ зөрчих
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох

Таны хувьд жолооч нарыг замын хөдөлгөөний дүрэм зөрчихөд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийг сонгоно уу. (3 хариулт сонгоно уу)

- Замын ачаалал, түгжрэл
- Яарч сандарсан үед
- Дүрмийн мэдлэг дутмаг
- Замын цагдаагийн хяналт сул
- Бусад жолоочийг дагаж
- Торгуулийн хэмжээ нь зөрчил үйлдэхгүй байх хөшүүрэг болж чадахгүй тул
- Хувийн хариуцлага сул

- Other:

Та ямар хүчин зүйлсийн улмаас замын хөдөлгөөний дүрмийг зөрчдөг вэ? (3 хариулт сонгоно уу)

- Замын ачаалал, түгжрэл
- Яарч сандарсан үед
- Дүрмийн мэдлэг дутмаг
- Замын цагдаагийн хяналт сул
- Бусад жолоочийг дагаж
- Торгуулийн хэмжээ нь зөрчил үйлдэхгүй байх хөшүүрэг болж чадахгүй тул
- Хувийн хариуцлага сул

Other:

Та замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагын талаар хэр сайн мэдэх вэ? (1–5 оноо: 1=мэдэхгүй, 5=маш сайн мэднэ)

- 1
- 2
- 3
- 4
- 5

Таны бодлоор одоо мөрдөгдөж буй торгуулах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1–5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=маш үр нөлөөтэй)

- 1
- 2
- 3
- 4
- 5

Таны бодлоор одоо мөрдөж буй жолоодох эрх хасах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1–5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=маш үр нөлөөтэй)

- 1
- 2
- 3
- 4
- 5

Таны бодлоор одоо мөрдөгдөж буй баривчлах эрх зүйн хариуцлага үр нөлөөтэй юу? (1–5 оноо: 1=үр нөлөөгүй, 5=маш үр нөлөөтэй)

- 1
- 2
- 3
- 4
- 5

Дараах зөрчлийн шийдвэрлэлтүүдээс аль нь жолоочид дахин зөрчил үйлдэхгүй байхад нөлөөлдөг гэж та үзэж байна вэ?

- Торгууль
- Жолоодох эрх хасах
- Баривчлах
- Таны бодлоор замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад аль арга хэмжээ хамгийн үр дүнтэй вэ?
- Торгуулийн хэмжээг нэмэх
- Хяналт шалгалтыг сайжруулах
- Жолоочийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, сургалтыг нэмэгдүүлэх
- Жолоодох эрх хасах арга хэмжээг чангатгах
- Камер, цахим хяналтыг нэмэгдүүлэх
- Замын зохион байгуулалтыг сайжруулах
- Other:

Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулах талаар таны санал

Ухаалаг камерын системийн талаарх таны бодол юу вэ? (Ai)

Ухаалаг камерын системийн зөрчил илрүүлэлт болон торгууль ногдуулдаг журмынталаар мэдээлэл хангалттай авч чадаж байна уу?

- Тийм
- Үгүй

Ухаалаг камер, AI хяналттай үед та дүрэм зөрчихөөс илүү болгоомжилдог уу?

- Тийм
- Үгүй

Аль нь илүү үр дүнтэй гэж та үзэж байна вэ?

- Цагдаагийн хяналт
- Ухаалаг камер, автомат хяналт
- Хосолсон хэлбэр

Яагаад тэгж үзэж байна вэ?

Хавсралт 2 Судалгааны ярилцлагын удирдамж



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

<u>ЗАМЫН</u> <u>ХӨДӨЛГӨӨНИЙ</u> <u>ДҮРМИЙН ЗӨРЧИЛД</u> <u>ХҮЛЭЭЛГЭХ ХУУЛЬ</u> <u>ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН</u> <u>ҮР НӨЛӨӨГ СУДЛАХ</u> <u>НЬ</u>	<u>Чанарын судалгааны ярилцлагын удирдамж</u>
Модераторт зориулсан Ярилцлагын удирдамжийн тайлбар – энэ нь модераторт зориулагдсан хөтөч, ярилцлагын удирдамж бөгөөд ярилцлагын явцад зорилтот бүлэгт тохирсон үг хэллэг хэрэглэж болно. Ярилцлагын дарааллыг модератор өөрийн мэдрэмжээрээ зохицуулж болно.	
УДИРДАМЖИЙН БҮТЭЦ	
ХЭСЭГ 1: Танилцуулга	
ХЭСЭГ 2: Ерөнхий мэдээлэл	
ХЭСЭГ 3: Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн нөхцөл байдал	
ХЭСЭГ 4: Хэрэгжилт ба хяналт	
ХЭСЭГ 5: Нэмэлт санал хүсэлт	
ХЭСЭГ 6: Нэмэлт асуулт	

--

ХЭСЭГ 1: Танилцуулга

ЗОРИЛГО: Энэхүү судалгааны зорилго нь “Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын үр нөлөөг судлах нь” сэдэвт судалгааны хүрээнд явагдаж байна.

- **МОДЕРАТОР ӨӨРИЙГӨӨ БОЛОН СУРГУУЛИА ТОВЧ ТАНИЛЦУУЛАХ**
- **СУДАЛГААГ ТАНИЛЦУУЛАХ**
- **СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДОД АНХААРУУЛАХ**
 - Зөв/буруу хариулт гэж үгүй
 - Бусдын санаа бодолд хүндэтгэлтэй хандах
 - Оролцогч хүсвэл хувь хүний нууцыг хадгална
 - Протокол хөтөлж буй болон дуу хураагуур ашиглахыг тайлбарлах

ХЭСЭГ 2: Ерөнхий мэдээлэл

- Та хэдэн жил замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр ажиллаж байна вэ?
- Өдөрт дунджаар хэдэн зөрчил илрүүлж, шийдвэрлэдэг вэ?

ХЭСЭГ 3: Замын хөдөлгөөний зөрчлийн нөхцөл байдал

- Одоогийн хууль зүйн хариуцлагын арга хэмжээ (торгууль, эрх хасах, баривчлах) жолооч нарын давтан зөрчил үйлдэхээс хэр үр дүнтэй сэргийлж байгаа гэж дүгнэж байна вэ? Яагаад?
- Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил болон оногдуулж буй торгуулийн хэмжээ нь танд хэр нийцтэй санагдаж байна вэ? Яагаад?

ХЭСЭГ 4: Хэрэгжилт ба хяналт

- Хууль хэрэгжүүлэх явцад ямар хүндрэл, бэрхшээл тулгардаг вэ?
- Зөрчил гаргасан жолооч нар шийтгэлээс зайлсхийх оролдлого гаргадаг уу? Хэрхэн?
- Хяналт, шалгалтын тогтолцоо хангалттай түвшинд байна гэж үзэж байна уу?

- Мөрдөгдөж буй торгуулийн систем нь оновчтой хэрэгжиж байгаа гэж үзэж байна уу? Хэрвээ үгүй бол таны бодлоор ямар шинэчлэлт болон зохицуулалт шаардлагатай вэ?
- Торгуулийн 50% хөнгөлөлт (14 хоногт төлбөл) нь хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байна гэж үзэж байна вэ?
- Таны хувьд ухаалаг камерын систем хэрэгжилт нь үр нөлөөтэй гэж үзэж байна уу? (Асуудал) Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээ эсвэл шийдэл санал болговол юу байх вэ?

ХЭСЭГ 5: Нэмэлт асуулт

- Одоогийн хууль зүйн хариуцлагын тогтолцоонд ямар өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна вэ?
- Гадаад улсын ямар туршлагыг Монголд нэвтрүүлэх боломжтой гэж бодож байна вэ?
- Зөрчил бууруулахын тулд зөвхөн шийтгэлээс гадна өөр ямар арга хэмжээ хэрэгтэй вэ?

ХЭСЭГ 6: Нэмэлт санал, зөвлөмж

- Цаашид замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бууруулахад хамгийн үр дүнтэй бодлого юу байх ёстой гэж та үзэж байна вэ?

ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЭХ

